

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/28/НА-СТА-ТЕЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он</p>	<p>Тусгай чиг үүргийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор : Д.Баярсайхан Утас: 51-261663 Цахим хаяг: bayarsaikhand@audit.gov.mn Аудитын менежер: П.Чанцалдулам Утас: 51-261885 Цахим хаяг: chantsaldulamp@audit.gov.mn Аудитор: Т.Баасанцэнд Утас: 51-261740 Цахим хаяг: baasantsendt@audit.gov.mn Аудитор: Г.Тэлмүүн Утас: 51-261740 Цахим хаяг: telmuung@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	11
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	12
3.1 Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний эрхлэх асуудал.....	12
3.2 Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний эрхлэх асуудлын хүрээний хууль, эрх зүйн орчин	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	20
4. АУДИТЫН ТАЙЛАН	25
4.1 Ерөнхий зүйл.....	25
4.2 Материаллаг байдал	25
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	25
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	25
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	30
5.2.1 Төлбөрийн акт	31
5.2.2 Албан шаардлага.....	32
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	36

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БНҮҮС	Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан
ГЕН	Гэрээний ерөнхий нөхцөл
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
КАБЗАА	Кибер аюулгүй байдлын зөвлөлийн ажлын алба
КХЗТНТ	Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв
МХС	Мэдээлэл холбооны сүлжээ
МТҮП	Мэдээлэл технологийн үндэсний парк
МШ	Монгол шуудан
МЦХ	Монголын цахилгаан холбоо
РТҮС	Радио телевизийн үндэсний сүлжээ
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ТӨААТҮГ	Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТӨХХК	Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТЦҮЗГ	Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар
УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар
ҮДТ	Үндэсний дата төв
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЦХИХХЯ	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам
ЦХИХХС	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд



ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ, ХАРИЛЦАА
ХОЛБООНЫ САЙД Ч.НОМИН ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

Засгийн газрын IV байр, Бага тойруу-3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26-04-37, Факс: (976-51) 26 42 30
Цахим шуудан: info@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026. 04. 24 № 1134
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-т заасны дагуу Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдаагүй нийт зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 4,413.8 сая төгрөгөөр давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Авлага, өглөгийн 1,186.4 сая төгрөгийн үлдэгдлийг бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулаагүй;
- Санхүүгийн тайланд 787.2 сая төгрөгийн өр төлбөрийг тусгаагүй;
- Өөрийн чиг үүрэгт хамааралгүй 432.9 сая төгрөгийн ажил үйлчилгээг хэрэгжүүлэхээр худалдан авах ажиллагааг зохион байгуулж, санхүүжүүлсэн;
- Цалин хөлс, урамшууллыг 487.9 сая төгрөгөөр илүү тооцож, давхардуулан олгосон,

- Төсөв санхүүгийн зохистой удирдлагыг хэрэгжүүлээгүйгээс 401.2 сая төгрөгийн өр төлбөр нэмэгдсэн;
- Төсвийн төсөлд санал өгч, батлуулаагүй 206.8 сая төгрөгийн арга хэмжээг санхүүжүүлсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.8, 14 дүгээр зүйлийн 14.2, 14.2.3, 14.2.5, 14.2.10, 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.3, 69 дүгээр зүйлийн 69.3-т заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулиар Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд 8,663.3 сая төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 16,122.7 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, төлөвлөгөөг 86.1 хувиар давуулан биелүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл жил бүр өсөж, 2025 оны жилийн эцсийн байдлаар 20,375.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй, сүүлийн 3 жилд сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэл нийт 11,913.0 сая төгрөг байна. Иймд сангийн хэрэгжүүлэх арга хэмжээг улсын төсвийн хөрөнгө оруулалтаас мөн адил хэрэгжүүлж давхардуулан санхүүжүүлж байгаа асуудалд дүн шинжилгээ хийж, сангийн үйл ажиллагааг эрчимжүүлж мөнгөн хөрөнгийн удирдлагыг сайжруулах шаардлагатай байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу аудитын мөрөөр хяналт тавих арга хэмжээ буюу өмнөх аудитаар өгсөн аудитын шийдвэрт дурдсан асуудлыг шалгаагдагч байгууллага хэрхэн хэрэгжүүлж, шийдвэрлэснийг аудитор хянаж, үнэлэх үүрэг хүлээдэг. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	152,739,642.3	136,440,384.3
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	35,106,497.9	34,726,045.3
33	АВЛАГА	27,027,226.6	32,149,953.5
34	УРЬДЧИЛГАА	11,278,841.7	4,738,827.1
35	БАРАА МАТЕРИАЛ	15,427,979.7	15,325,984.8
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	63,899,096.4	49,499,573.6
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	360,153,948.6	377,501,270.7
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	167,030.7	143,019.4
37200	Үнэт цаас	500.0	500.0
37300	Урт хугацаат зээл	166,530.7	142,519.4
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	359,986,917.9	377,358,251.3
39200	Биет хөрөнгө	213,245,682.3	229,721,918.4
39300	Биет бус хөрөнгө	143,830,941.3	140,955,997.9
39400	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	2,910,294.3	6,680,335.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	512,893,590.9	513,941,655.0
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	107,361,886.2	100,799,076.3
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	35,726,582.7	33,439,554.7
41300	Өглөг	31,768,241.2	31,268,716.5
41400	Урьдчилж орсон орлого	3,958,341.5	2,170,838.2
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	71,635,303.4	67,359,521.6
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	405,531,704.7	413,142,578.7
51	Засгийн газрын хувь оролцоо	402,008,669.5	409,619,543.5
51100	Засгийн газрын оруулсан капитал	6,863,456.7	6,863,456.7
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	227,806,661.7	227,806,661.7
51105	Нэмж төлөгдсөн капитал /ТӨҮГ/	2,538,512.2	2,538,512.2
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	80,018,571.0	81,527,147.2
51200	Хуримтлагдсан үр дүн	41,818,327.0	49,392,112.8
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	42,963,140.9	41,491,653.0
52	Хяналтын бус хувь оролцоо	3,523,035.2	3,523,035.2
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	512,893,590.9	513,941,655.0

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	105,623,497.5	120,140,873.3
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	40,881,583.4	120,140,873.3
122	Тусламжийн орлого	-	55,699,480.1
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	64,741,914.2	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	96,102,809.5	97,484,353.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	96,102,809.5	97,484,353.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	87,607,772.5	89,835,694.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	20,637,439.3	24,010,080.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,565,680.0	3,003,542.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,821,581.9	5,299,047.9
2104	Хангамж, бараа материалын зардал	1,165,640.3	934,348.8
2105	Нормативт зардал	27,999.6	99,642.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,635,809.3	512,509.3
2107	Томилолт, зочны зардал	935,118.6	307,892.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	33,332,151.9	32,090,940.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,486,351.5	23,577,689.6
212	ТАТААС	1,500,000.0	1,350,000.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,995,037.0	6,298,659.2
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	9,520,688.1	22,656,520.0
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	1,370,865.6	424,076.0
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	6,067,637.6	15,521,940.3
VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	(4,696,772.0)	(15,097,864.3)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	4,823,916.0	7,558,655.7

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	221,897,246.2	217,841,317.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	157,155,524.7	217,841,317.0
120	Нийтлэг татварын бус орлого	157,155,524.7	162,117,956.6
122	Тусламжийн орлого	-	55,723,360.4
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	64,741,721.6	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	191,191,377.4	181,192,076.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	191,191,377.4	181,192,076.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	182,842,437.5	171,756,873.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	59,005,165.8	75,710,099.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	13,299,437.0	2,995,370.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,634,711.9	24,538,922.9
2104	Хангамж, бараа материалын зардал	18,322,618.0	16,329,403.5
2105	Нормативт зардал	45,544.9	102,336.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	852,596.9	439,026.6
2107	Томилолт, зочны зардал	730,244.7	270,460.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	56,686,263.2	49,541,664.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,265,855.0	1,829,589.8
212	ТАТААС	1,500,000.0	1,346,915.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,848,940.0	8,088,288.2
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	30,705,868.8	36,649,240.1
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	598,742.8	310,834.8
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	32,540,866.6	32,748,831.4

22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	32,540,866.6	32,748,831.4
2200	Дотоод эх үүсвэрээр	32,540,866.6	32,748,831.4
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(31,942,123.8)	(32,437,996.6)
14	Бусад эх үүсвэр	27,670.2	3,901,393.7
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	3,708,354.4	8,493,089.7
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(3,680,684.2)	(4,591,696.1)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(4,916,939.2)	(380,452.6)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	40,023,437.1	35,106,497.9
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	35,106,497.9	34,726,045.3

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Дансны нэр, төрөл	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	317,215,002.1	42,854,187.7	38,194,762.1	398,263,951.9
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(858,872.6)	(858,872.6)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	317,215,002.1	42,854,187.7	37,335,889.5	397,405,079.3
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	137,452.8	-	137,452.8
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	(28,499.5)	28,499.5	-
7	Өмчид гарсан өөрчлөлт	3,535,234.7	-	-	3,535,234.7
8	Зарласан ногдол ашиг	-	-	(369,978.1)	(369,978.1)
9	Тайлант үеийн үр дүн	-	-	4,823,916.0	4,823,916.0
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	320,750,236.8	42,963,140.9	41,818,327.0	405,531,704.7
11	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	320,750,236.8	42,963,140.9	41,818,327.0	405,531,704.7
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	746,188.4	746,188.4
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	320,750,236.8	42,963,140.9	42,564,515.4	406,277,893.1
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	(1,471,488.0)	-	(1,471,488.0)
17	Өмчид гарсан өөрчлөлт	1,508,576.1	-	-	1,508,576.1
18	Зарласан ногдол ашиг	-	-	(731,058.2)	(731,058.2)
19	Тайлант үеийн үр дүн	-	-	7,558,655.7	7,558,655.7
20	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	322,258,812.9	41,491,653.0	49,392,112.8	413,142,578.7

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	78,828,530,900.00	68,217,149,801.57	10,611,381,098.43	86.5
Татварын бус орлого	78,828,530,900.00	68,217,149,801.57	10,611,381,098.43	86.5
Нийтлэг татварын бус орлого	8,663,273,900.00	16,122,787,576.89	(7,459,513,676.89)	186.1
Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	8,663,273,900.00	16,122,787,576.89	(7,459,513,676.89)	186.1
Тусламжийн орлого	70,165,257,000.00	52,094,362,224.68	18,070,894,775.32	74.2
Төсвөөс санхүүжих	70,165,257,000.00	52,094,362,224.68	18,070,894,775.32	74.2
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	81,974,230,900.00	63,372,299,007.41	18,601,931,892.59	77.3
УРСГАЛ ЗАРДАЛ	58,611,430,900.00	51,382,300,395.41	7,229,130,504.59	87.7
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	49,764,198,500.00	43,065,172,041.41	6,699,026,458.59	86.5
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	22,053,601,800.00	19,774,327,081.25	2,279,274,718.75	89.7
Үндсэн цалин	15,246,409,600.00	14,236,901,027.01	1,009,508,572.99	93.4
Нэмэгдэл	3,294,454,400.00	1,727,997,458.37	1,566,456,941.63	52.5
Унаа хоолны хөнгөлөлт	1,443,141,500.00	2,066,240,481.57	(623,098,981.57)	143.2
Урамшуулал	2,069,596,300.00	1,743,188,114.30	326,408,185.70	84.2
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,782,938,100.00	2,476,065,368.60	306,872,731.40	89.0
Тэтгэврийн даатгал	1,886,820,000.00	1,690,347,867.30	196,472,132.70	89.6
Тэтгэмжийн даатгал	224,129,900.00	200,808,844.09	23,321,055.91	89.6
ҮОМШӨ-ний даатгал	112,027,600.00	99,242,990.87	12,784,609.13	88.6
Ажилгүйдлийн даатгал	111,995,000.00	104,464,678.25	7,530,321.75	93.3
Эрүүл мэндийн даатгал	447,965,600.00	381,200,988.09	66,764,611.91	85.1
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,789,892,200.00	2,686,545,068.05	103,347,131.95	96.3
Гэрэл, цахилгаан	1,278,631,900.00	1,245,760,542.33	32,871,357.67	97.4
Түлш, халаалт	113,167,300.00	121,372,411.44	(8,205,111.44)	107.3
Цэвэр, бохир ус	100,349,900.00	101,164,964.28	(815,064.28)	100.8
Байрны түрээс	1,297,743,100.00	1,218,247,150.00	79,495,950.00	93.9
Хангамж, бараа материалын зардал	877,024,300.00	563,766,793.74	313,257,506.26	64.3
Бичиг хэрэг	185,120,300.00	113,528,295.00	71,592,005.00	61.3
Тээвэр, шатахуун	18,954,000.00	9,497,380.00	9,456,620.00	50.1
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	412,635,100.00	275,665,357.98	136,969,742.02	66.8
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	43,848,400.00	30,808,320.00	13,040,080.00	70.3
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	216,466,500.00	134,267,440.76	82,199,059.24	62.0
Нормативт зардал	111,089,000.00	96,063,000.00	15,026,000.00	86.5
Хоол, хүнс	92,832,000.00	78,321,000.00	14,511,000.00	84.4
Нормын хувцас, зөөлөн эдлэл	18,257,000.00	17,742,000.00	515,000.00	97.2
Эд хогшил, урсгал засварын зардал	450,472,600.00	418,585,305.00	31,887,295.00	92.9
Багаж, техник, хэрэгсэл	214,151,000.00	157,840,890.00	56,310,110.00	73.7
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,387,000.00	-	4,387,000.00	-
Урсгал засвар	231,934,600.00	260,744,415.00	(28,809,815.00)	112.4
Томилолт, зочны зардал	266,995,500.00	190,262,803.80	76,732,696.20	71.3
Гадаад албан томилолт	89,306,200.00	86,032,823.80	3,273,376.20	96.3
Дотоод албан томилолт	176,057,900.00	103,850,183.00	72,207,717.00	59.0
Зочин төлөөлөгч хүлээн авах	1,631,400.00	379,797.00	1,251,603.00	23.3
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,522,092,100.00	14,634,488,636.97	2,887,603,463.03	83.5
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,442,431,100.00	8,007,215,336.00	2,435,215,764.00	76.7
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	89,662,700.00	57,845,000.00	31,817,700.00	64.5
Даатгалын үйлчилгээ	4,158,700.00	1,871,476.00	2,287,224.00	45.0
Тээврийн хэрэгслийн татвар	2,467,700.00	1,944,967.75	522,732.25	78.8
Тээврийн хэрэгслийн оношлогоо	314,600.00	22,000.00	292,600.00	7.0

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын
2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,965,259,200.00	6,554,076,107.22	411,183,092.78	94.1
Газрын төлбөр	4,201,300.00	10,500.00	4,190,800.00	0.2
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	32,200.00	32,150.00	50.00	99.8
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	13,564,600.00	11,471,100.00	2,093,500.00	84.6
Бараа үйлчилгээний бусад зардал	2,910,092,900.00	2,225,067,984.00	685,024,916.00	76.5
Бараа үйлчилгээний бусад зардал	2,727,019,600.00	2,043,715,084.00	683,304,516.00	74.9
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	183,073,300.00	181,352,900.00	1,720,400.00	99.1
ТАТААС	6,554,987,500.00	6,554,987,500.00	-	100.0
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	5,208,072,300.00	5,208,072,300.00	-	100.0
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	5,208,072,300.00	5,208,072,300.00	-	100.0
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	1,346,915,200.00	1,346,915,200.00	-	100.0
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	1,346,915,200.00	1,346,915,200.00	-	100.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,292,244,900.00	1,762,140,854.00	530,104,046.00	76.9
Засгийн газрын урсгал шилжүүлэг	2,146,687,400.00	1,683,191,854.00	463,495,546.00	78.4
Засгийн газрын гадаад шилжүүлэг	2,146,687,400.00	1,683,191,854.00	463,495,546.00	78.4
Бусад урсгал шилжүүлэг	145,557,500.00	78,949,000.00	66,608,500.00	54.2
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	49,304,300.00	9,549,000.00	39,755,300.00	19.4
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	85,153,200.00	64,800,000.00	20,353,200.00	76.1
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,100,000.00	4,600,000.00	6,500,000.00	41.4
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	23,362,800,000.00	11,989,998,612.00	11,372,801,388.00	51.3
Барилга байгууламж	16,499,400,000.00	5,147,572,573.00	11,351,827,427.00	31.2
Тоног төхөөрөмж	6,863,400,000.00	6,842,426,039.00	20,973,961.00	99.7
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	(3,145,700,000.00)	4,844,850,794.16	(7,990,550,794.16)	(154.0)
АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,145,700,000.00	(4,844,850,794.16)	7,990,550,794.16	(154.0)
Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	3,145,700,000.00	(4,844,850,794.16)	7,990,550,794.16	(154.0)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	17,956,709,707.84	(17,956,709,707.84)	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	19,471,155,396.73	(19,471,155,396.73)	-
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	986	917	69	93.0
БАЙГУУЛЛАГЫН ТОО	6	6	-	100.0
Төсвийн байгууллага	6	6	-	100.0
АЖИЛЛАГСАДЫН ТОО	490	450	40	91.8
Удирдах ажилтан	38	26	12	68.4
Гүйцэтгэх ажилтан	411	387	24	94.2
Үйлчлэх ажилтан	41	37	4	90.2
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	490	461	29	94.1
Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	92	73	19	79.3
Ажлын албаны албан хаагч (АА)	7	7	-	100.0
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	144	143	1	99.3
Улс төрийн албан хаагч (УТ)	1	1	-	100.0
Шатлалгүй цалин	240	232	8	96.7
Төрийн үйлчилгээний мэргэжлийн (ТҮМ)	6	5	1	83.3

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Код	Дансны нэр, төрөл	Төлөвлөлт	Гүйцэтгэл
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	-	1,063,997,836.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	1,063,997,836.40
122	Тусламжийн орлого	-	1,063,997,836.40
1221	Хандив тусламж /дотоод/	-	1,063,997,836.40
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	1,063,997,836.40
350011	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	40,895,000.00
350013	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	137,687,844.40
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	885,414,992.00
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	946,694,429.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	946,694,429.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	828,291,858.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	19,285,273.50
210101	Үндсэн цалин	-	5,397,702.82
210102	Нэмэгдэл	-	13,887,570.68
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	19,148,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	19,148,000.00
2107	Томилолт, зочны зардал	-	16,850,005.00
210702	Дотоод албан томилолт	-	16,850,005.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	773,008,580.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	581,932,700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	191,075,880.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	118,402,570.90
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	118,402,570.90
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	118,402,570.90
4	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-	117,303,407.00
5	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	(117,303,407.00)
6	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	(117,303,407.00)

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний эрхлэх асуудал

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам нь эрхэм зорилгоо “Монгол Улсын нийгэм, эдийн засгийн салбарт харилцаа холбоо, мэдээллийн технологийн дэвшилтэт технологийг нэвтрүүлж, мэдлэг оюунд тулгуурласан цахим үндэстнийг цогцлоон хөгжүүлнэ” гэж тодорхойлсон байна.

Эрхэм зорилгын хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг дэвшүүлэн хэрэгжүүлж байна. Үүнд:

- Хиймэл оюун, их өгөгдөл, кибер аюулгүй байдал, инновац болон харилцаа холбоо, дижитал шилжилтийн хөгжлийн үндэсний бодлого, стратеги, дунд ба урт хугацааны хөтөлбөрүүдийг боловсруулж батлуулах, хэрэгжилтийг уялдуулан зохицуулах, бодлогын судалгаа, төлөвлөлтийн аргачлалыг сайжруулж, өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалтыг дэмжих. Олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлж, дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх төсөл, хөтөлбөрийг боловсруулж, удирдамжаар хангах;
- Хүний нөөц, санхүү, хөрөнгө оруулалт, хууль эрх зүй, гадаад хамтын ажиллагааг төлөвлөж, зохион байгуулах, төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл нийгмийн баталгаа болон яамны хэвийн, үр ашигтай үйл ажиллагааг хангах, хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөрийн санхүүгийн төлөвлөлт, гүйцэтгэлийг сайжруулах, хууль ёсны хүрээнд хяналттай хэрэгжүүлэх;
- Хүн төвтэй дижитал засаглал болон инновацын бодлого, стратеги, төслүүдийн хэрэгжилтийг уялдуулан зохион байгуулах, хяналт тавих, төрийн үйлчилгээний бүх төрлийг цахимаар авах боломжийг бүрдүүлж, хэрэгжилтийг зохион байгуулах, төрийн байгууллагуудын дижитал чадавхыг бэхжүүлэх, нээлттэй инновацын эко системийг хөгжүүлэх, хувийн хэвшил, судалгааны байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх;
- Харилцаа холбооны салбарын бодлого, эрх зүйн орчны хэрэгжилтийг зохион байгуулах, дэд бүтэц, үйлчилгээний хүртээмж, чанар, найдвартай байдлыг хангах, хөгжлийг хурдасгах, сансрын холбооны дэд бүтцийг хөгжүүлэх стратеги боловсруулж батлуулах хэрэгжилтийг хангах, үндэсний кибер аюулгүй байдлыг бэхжүүлэх, эрсдэлийг бууруулах, холбогдох хууль, стандарт, зохицуулалтын хэрэгжилтийг хангуулж ажиллах;
- Хөгжлийн бодлогын баримт бичиг, салбарын стратегийн төлөвлөгөө болон төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн гүйцэтгэлийг хангуулж, хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудит хийж, сайжруулах зөвлөмж боловсруулах, эрсдэлд суурилсан хяналт шалгалт хэрэгжүүлэх замаар холбогдох хууль, тогтоомж, техникийн зохицуулалт, стандартын хэрэгжилт, харилцаа холбоо, мэдээллийн технологийн ашиглалт, үйлчилгээний тасралтгүй, хэвийн, найдвартай ажиллагааг хангах.

Дээрх чиг үүргийг хэрэгжүүлэхийн тулд Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.36-д *“төсвийн ерөнхийлөн захирагч” гэж өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийг төлөвлөх, батлагдсан төсвийг хууль тогтоомжийн дагуу хуваарилах, хяналт тавих, захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг*” гэж заасны дагуу Монгол Улсын ерөнхий сайдын 2026 оны 76 дүгээр захирамжаар томилогдсон Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ч.Номин нь төсвийн ерөнхийлөн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Тайлант онд Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайланд төсвийн шууд захирагч 4, засгийн газрын тусгай сан 2, төрийн өмчит үйлдвэрийн газар 7, нийт 13 байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэжээ.

3.2 Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний эрхлэх асуудлын хүрээний хууль, эрх зүйн орчин

Төсвийн ерөнхийлөн захирагч нь үйл ажиллагаандаа Харилцаа холбооны тухай хууль, Шуудангийн тухай хууль, Радио долгионы тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хууль, Өргөн нэвтрүүлгийн тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль, Инновацийн тухай хууль, Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжуудыг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд Төсвийн ерөнхийлөн захирагчийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай;
- Засгийн газрын 2024 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 238 дугаар тогтоол;
- Засгийн газрын 2025 оны “Яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай” 07 дугаар тогтоол;
- Засгийн газрын 2025 оны “Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсийн ажиллах журам”, “Виртуал бүсэд бүртгэлтэй хуулийн этгээдэд татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэх журам” 98 дугаар тогтоол;
- Засгийн газрын 2025 оны “Цахимаар нэн тэргүүнд бодлогын зөвлөмж батлах тухай” 108 дугаар тогтоол;
- Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны “Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай” 04 дүгээр албан даалгавар;
- Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны “Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай” 05 дугаар албан даалгавар;
- Монгол Улсын Сангийн сайдын 2025 оны “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ыг А/3 дугаар тушаал шинэчлэн баталсан;

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзлээ.

Салбарын хяналт, шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газар нь Монгол улсын засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам", Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2024 оны А/38 тушаалаар баталсан "Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам"-ыг мөрдөн ажиллаж байна.

Тайлант онд дараах хяналт шинжилгээ, үнэлгээг хийж, тайланг холбогдох газруудад хүргүүлсэн байна. Үүнд:

- Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу “Алсын хараа-2050” хөтөлбөрт туссан 69 арга хэмжээний 2025 оны хэрэгжилтэд үнэлгээ хийж, хэрэгжилтийг 77.7 хувиар үнэлж, тайланг Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт хүргүүлсэн;
- Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан 1 арга хэмжээний биелэлтийг үнэлж, хэрэгжилтийг 100.0 хувьтай үнэлж, тайланг Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлсэн;
- Сайдын баталсан Салбарын хяналт, шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу салбарын хяналтын улсын байцаагч

нар нийт 1127 объектод эрсдэлийн ангиллын үнэлгээ хийж, 2026 оны төлөвлөгөөт шалгалт хийх их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 171 объектын жагсаалтыг Засгийн газрын хэрэг эрхлэх газарт 01/2455 дугаартай бичгээр хүргүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккурэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны А/54 дүгээр тушаалаар баталсан Сайдын эрхлэх асуудлын хүрээний төсөвт байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд баримтлах Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,048.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	35,106.5	34,726.0	(380.5)
Авлага	27,027.2	32,150.0	5,122.8
Урьдчилгаа	11,278.8	4,738.8	(6,540.0)
Бараа материал	15,428.0	15,326.0	(102.0)
Бусад эргэлтийн хөрөнгө	63,899.1	49,499.6	(14,399.5)
Урт хугацаат хөрөнгө оруулалт	167.0	143.0	(24.0)
Үндсэн хөрөнгө	359,987.0	377,358.3	17,371.3
Нийт хөрөнгө	512,893.6	513,941.7	1,048.1
Богино хугацаат өр төлбөр	35,726.6	33,439.6	(2,287.0)
Урт хугацаат өр төлбөр	71,635.3	67,359.6	(4,275.7)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	402,008.7	409,619.5	7,610.8
Хяналтын бус хувь оролцоо	3,523.0	3,523.0	-
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	512,893.6	513,941.7	1,048.1

Эх сурвалж: Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Дээрх хүснэгтээс харахад, өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан авлага, урьдчилгаа, бусад эргэлтийн хөрөнгө, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо данснууд байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 34,726.0 сая төгрөг болж, өмнөх оноос 380.5 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Кассад байгаа бэлэн мөнгө	166.2	34.1	(132.1)
Банканд байгаа бэлэн мөнгө	34,940.2	30,586.1	(4,354.1)
Төгрөг	25,775.1	30,456.2	4,681.1
Төрийн сангийн харилцах	20,434.4	22,500.6	2,066.2
Арилжааны банк дахь харилцах	5,340.7	7,955.6	2,614.9
Гадаад валют	9,165.1	129.9	(9,035.2)
Арилжааны банк дахь харилцах	9,165.1	129.9	(9,035.2)
Замд яваа мөнгөн хөрөнгө	-	3.2	3.2
Хадгаламж	0.1	4,102.5	4,102.4
Дүн	35,106.5	34,726.0	(380.5)

Эх сурвалж: Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдлийн 58.7 хувь буюу 20,375.6 сая төгрөг БНҮҮС, 25.8 хувь буюу 8,943.6 сая төгрөг МШ ХК, 15.5 хувь буюу 5,406.8 сая төгрөг бусад байгууллагын мөнгөн хөрөнгө байна. Мөнгөн хөрөнгийн үлдэгдлээс арилжааны банканд байршиж буй валютын харилцах дансны үлдэгдэл 129.9 сая төгрөг, төгрөгийн харилцах дансны үлдэгдэл 30,456.3 сая төгрөг, хадгаламж 4,102.5 сая төгрөг, кассад байгаа бэлэн мөнгө 34.1 сая төгрөг, замд яваа мөнгөн хөрөнгө 3.2 сая төгрөг байна.

Аудитын илрүүлэлт:

- Ажилчдын цалин хөлс, урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэлийг зөрүүтэй олгож, тайлагнасан нийт 410.5 сая төгрөг. / ЦХИХХЯ 151.8 сая төгрөг, ҮДТ УТУГ 134.7 сая төгрөг, РТҮС УТУГ 67.4 сая төгрөг, МЦХ ХК 48.3 сая төгрөг, ТЦҮЗГ 3.7 сая төгрөг, МТҮП ТӨААТҮГ 2.6 сая төгрөг, МХС ТӨХХК 2.0 сая төгрөг/;
- Төсвийн төсөлд тусгаж, батлуулаагүй зардлыг санхүүжүүлсэн нийт 206.8 сая төгрөг /ЦХИХХЯ 118.5 сая төгрөг, ТЦҮЗГ 88.3 сая төгрөг/;
- Төсвийг үр ашиггүй зарцуулсан нийт 139.1 сая төгрөг. /ЦХИХХЯ 80.0 сая төгрөг, ТЦҮЗГ 40.5 сая төгрөг, БНҮҮС 18.6 сая төгрөг/;
- Анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэсэн нийт 122.1 сая төгрөг. / РТҮС УТУГ 118.2 сая төгрөг, МТҮП ТӨААТҮГ 3.9 сая төгрөг/;
- Жижиг мөнгөн сангийн ашиглалт, зарцуулалтыг хууль тогтоомжид нийцээгүй нийт 133.5 сая төгрөг. /МЦХ ХК/;
- Өөрийн орлогоор 100.0 хувь санхүүждэг байгууллагад олгосон санхүүжилт 50.0 сая төгрөг, буруутай албан тушаалтны шийдвэрээр ажлаас чөлөөлөгдсөн албан хаагчийн нөхөн олговрыг байгууллагаас олгосон 15.8 сая төгрөг. /ЦХИХХЯ/;
- Бараа материалыг и баримтгүй худалдан авсан 16.2 сая төгрөг. /МЦХ ХК/;
- Орлогын дүнг зөрүүтэй илэрхийлсэн 11.9 сая төгрөг. / РТҮС УТУГ/;
- Бондын хүү тооцоогүй 1.7 сая төгрөг, хадгаламжийн хүүний орлогыг нэхэмжилж аваагүй 1.6 сая төгрөг. /МШ ХК/

3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 32,150.0 сая төгрөг болж, өмнөх оноос 5,122.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчтай холбогдсон авлага	0.5	37.2	36.7
Төлбөртэй үйлчилгээний авлага	651.8	391.5	(260.3)
Татаас, санхүүжилтийн авлага	43.4	1,998.2	1,954.8

Дансны авлага /ТӨҮГ/	23,270.0	26,162.7	2,892.7
Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	511.0	466.6	(44.4)
Байгууллагаас авах авлага	2,466.0	3,055.9	589.9
Хувь хүмүүсээс авах авлага	84.5	37.9	(46.6)
Дүн	27,027.2	32,150.0	5,122.8

Эх сурвалж: Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Нийт авлагын үлдэгдлийн 98.9 хувь буюу 29,537.6 сая төгрөгийг төрийн өмчит үйлдвэрийн газруудын авлага эзэлж байна. Тухайлбал: МХС ТӨХХК 17,671.3 сая төгрөг, МШ ХК 5,776.7 сая төгрөг, МЦХ ХК 5,766.1 сая төгрөг байна.

Авлага дансны өсөлтөд МХС ТӨХХК-ийн дансны авлага /ТӨҮГ/ 6,247.1 сая төгрөгөөр өсч, МЦХ ХК-ийн авлага 3,222.4 сая төгрөгөөр буурсан болон УДТ УТҮГ, РТҮС УТҮГ-уудын татаас санхүүжилтийн авлага 1,954.8 сая төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Аудитын илрүүлэлт:

- Авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй нийт 924.0 сая төгрөг. /МШ ХК 442.9 сая төгрөг, БНҮС 304.1 сая төгрөг, МТҮП ТӨААТҮГ 123.7 сая төгрөг, МХС ТӨХХК 53.3 сая төгрөг/;
- Авлага барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй нийт 209.0 сая төгрөг /МЦХ ХК 129.1 сая төгрөг, МШ ХК 67.8 сая төгрөг, РТҮС УТҮГ 12.1 сая төгрөг/

3.4.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эцсийн үлдэгдэл 4,738.8 сая төгрөг болж, өмнөх оноос 6,540.0 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 4. Урьдчилгаа дансны үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Төрийн өмчийн үйлдвэр, аж ахуйн газар	5,529.3	431.3	(5,098.0)
Урьдчилж гарсан зардал	5,749.1	4,306.0	(1,443.1)
Цалингийн урьдчилгаа	0.4	1.1	0.7
Томилолтын урьдчилгаа	-	0.4	0.4
Дүн	11,278.8	4,738.8	(6,540.0)

Эх сурвалж: Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Нийт урьдчилж гарсан зардлын үлдэгдлийн 92.8 хувийг төрийн өмчит үйлдвэрийн газар, 7.2 хувийг төсөвт байгууллага эзэлж байна.

Урьдчилгаа дансны үлдэгдэл буурсан нь МШ ХК-ийн он дамжин хэрэгжсэн Хөшигтийн хөндийн ялган боловсруулах төвийн санхүүжилтийн урьдчилгаа төлбөрийг хүлээн зөвшөөрч бүртгэсэн болон МЦХ ХК-ийн утасгүй дотоод сүлжээний төслийн хүрээнд бараа материалыг зээлээр авч, гэрээний дагуу урьдчилан төлсөн он дамжсан үлдэгдлээс голлон шалтгаалсан байна.

Аудитын илрүүлэлт:

- Өмнөх онд үүссэн онгоцны тийзийн урьдчилж төлсөн зардлыг улсын төсөвт төвлөрүүлээгүй 32.5 сая төгрөг. /ЦХИХХЯ /

3.4.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 15,326.0 сая төгрөг болж, өмнөх оноос 102.0 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	3,149.4	3,010.2	(139.2)
Тусгай зориулалттай материал	3,149.4	3,010.2	(139.2)
Дуусаагүй үйлдвэрлэл	288.7	348.0	59.3
Бэлэн бүтээгдэхүүн	3,591.8	2,880.3	(711.5)
Хангамжийн материал	8,398.1	9,087.5	689.4
Бичиг хэргийн материал	96.9	63.2	(33.7)
Аж ахуйн материал	2,036.3	2,107.3	71.0
Сэлбэг хэрэгсэл	3,142.7	3,734.3	591.6
Түлш, шатах тослох материал	1,255.2	836.9	(418.3)
Барилгын засварын материал	18.4	17.8	(0.6)
Бусад хангамжийн материал	1,848.6	2,328.0	479.4
Дүн	15,428.0	15,326.0	(102.0)

Эх сурвалж: Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Тайлант хугацаанд байгууллагуудын хэвийн үйл ажиллагаа хангахад нийт 18,870.4 сая төгрөгийн материал худалдан авч, 5.0 сая төгрөгийн материал шилжүүлэн авч, 18,971.4 сая төгрөгийн материалыг үйл ажиллагаандаа зарцуулж, 5.9 сая төгрөгийн материалыг шилжүүлэн өгч, 15,326.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Нийт бараа материал дансны үлдэгдлийн 90.5 хувийг төрийн өмчит үйлдвэрийн газар, 9.5 хувийг төсөвт байгууллага эзэлж байна. Бараа материал дансны бууралтад МЦХ ХК-ийн бэлэн бүтээгдэхүүн 806.0 сая төгрөгөөр, буурч, хангамжийн материал 732.5 сая төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Аудитын илрүүлэлт:

- Шаардлагагүй материал нөөцөлсөн, төлөвлөснөөс илүү худалдан авалт хийсэн нийт 367.0 сая төгрөг /МХС ТӨХХК 344.2 сая төгрөг, ЦХИХХЯ 25.8 сая төгрөг/

3.4.5 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 49,499.6 сая төгрөг болж, өмнөх оноос 14,399.5 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 6. Бусад эргэлтийн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/+Бусад	63,899.1	49,499.6	(14,399.5)
Дүн	63,899.1	49,499.6	(14,399.5)

Эх сурвалж: Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Бусад эргэлтийн хөрөнгө дансны үлдэгдэл нь төсвийн байгууллагуудтай холбоотой бөгөөд хөрөнгийн бууралтад ЦХИХХС-ын хөрөнгө оруулалтын зардлаас 11,990.0 сая төгрөгийн хөрөнгө бүртгэсэн, хэрэгжүүлсэн төслүүдийн гүйцэтгэл 22,000.0 сая төгрөгийн хөрөнгийг МХС ТӨХХК, ҮДТ УТҮГ, Дархан-Уул аймгийн ЗДТГ-т шилжүүлсэн болон БНҮҮС-аас 4,753.3 сая төгрөгийн үйлчилгээний зардлыг хүлээн зөвшөөрч, 285.1 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлсэн нь голлон нөлөөлсөн байна.

3.4.6 Урт хугацаат хөрөнгө оруулалт

Урт хугацаат хөрөнгө оруулалт дансны эцсийн үлдэгдэл 143.0 сая төгрөг болж, өмнөх оноос 24.0 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 7. Урт хугацаат хөрөнгө оруулалт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Үнэт цаас	0.5	0.5	-
Төгрөг	0.5	0.5	-
Урт хугацаат зээл	166.5	142.5	(24.0)
Урт хугацаат хөрөнгө оруулалт	166.5	142.5	(24.0)
Дүн	167.0	143.0	(24.0)

Эх сурвалж: Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Урт хугацаат хөрөнгө оруулалтын үлдэгдлийн бууралт нь МЦХ ХК-ийн охин компани Эм ти си сервис ХХК-д оруулсан хөрөнгө оруулалтаас 24.0 сая төгрөг төлөгдсөнтэй холбоотой байна.

3.4.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 377,358.3 сая төгрөг болж, өмнөх оноос 17,371.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 8. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	213,245.7	229,721.9	16,476.2
Барилга, байгууламж, орон сууц	46,774.3	50,222.4	3,448.1
Авто-тээврийн хэрэгсэл	8,499.4	9,090.1	590.7
Машин тоног төхөөрөмж(компьютер)	148,001.4	167,616.2	19,614.8
Тавилга, аж ахуйн эд хогшил	2,123.6	1,618.6	(505.0)
Зам, гүүрний байгууламж	-	-	-
Бусад үндсэн хөрөнгө	466.4	439.4	(27.0)
Дуусаагүй барилга, байгууламж	7,374.8	729.4	(6,645.4)
Ном	5.8	5.8	-
Биет бус хөрөнгө	143,830.9	140,956.0	(2,874.9)
Программ хангамж	11,023.5	7,563.7	(3,459.8)
Бусад биет бус хөрөнгө	132,807.4	133,392.3	584.9
Бусад хөрөнгө /ТӨҮГ/	2,910.4	6,680.4	3,770.0
Хойшлогдсон татварын хөрөнгө /ТӨҮГ/	2,795.4	2,634.3	(161.1)
Бусад эргэлтийн бус хөрөнгө /ТӨҮГ/	115.0	4,046.1	3,931.1
Дүн	359,987.0	377,358.3	17,371.3

Эх сурвалж: Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдлийн 99.1 хувийг төрийн өмчит үйлдвэрийн газар, 0.9 хувийг төсөвт байгууллага эзэлж байна. Нийт үндсэн хөрөнгийн үлдэгдлийн 60.9 хувийг биет хөрөнгө, 37.4 хувийг биет бус хөрөнгө, үлдсэн 1.7 хувийг бусад үндсэн хөрөнгө бүрдүүлсэн байна.

Тайлант онд 17,900.4 сая төгрөгийн хөрөнгө шинээр худалдан авч, 29,631.1 сая төгрөгийн хөрөнгийг улсын төсвийн хөрөнгө оруулалт, төслийн хүрээнд хандиваар болон шилжүүлэн авч, 24,320.4 сая төгрөгийн хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоосон, дахин үнэлснээр нэмэгдэж, 19,215.3 сая төгрөгийн хөрөнгө акталж, 315.4 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн өгч, 9,122.7 сая төгрөгийн дахин үнэлгээний хорогдол болон тайлант үеийн элэгдлийн зардал 25,827.2 сая төгрөгөөр буурсан байна.

Аудитын илрүүлэлт:

- Төслийн хүрээнд бий болсон хөрөнгийг балансаас балансад шилжүүлсэн боловч шилжүүлсэн байгууллагууд нь хүлээж аваагүй 248.7 сая төгрөг/ ЦХИХХЯ/;
- Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үлдэх өртөггүй болсон хөрөнгүүдийн үнийг шинэчлэн тогтоогоогүй нийт 101.9 сая төгрөг /ТЦҮЗГ 48.0 сая төгрөг, МШ ХК 36.8 сая төгрөг, УДТ УТҮГ 17.1 сая төгрөг/

3.4.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 100,799.2 сая төгрөг болж, өмнөх оноос 6,562.7 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 9. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Богино хугацаат өр төлбөр	35,726.6	33,439.6	(2,287.0)
Өглөг	31,768.3	31,268.8	(499.5)
Ажилчидтай холбогдсон өглөг	80.5	113.9	33.4
Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	1,940.2	1,940.2
Байгууллагад төлөх өглөг	9,803.4	10,060.5	257.1
Хувь хүмүүст төлөх өглөг	5.8	47.0	41.2
Татварын өглөг /ТӨҮГ/	2,825.2	3,057.5	232.3
НДШ-ийн өглөг /ТӨҮГ/	196.9	46.5	(150.4)
Ноогдол ашгийн өглөг /ТӨҮГ/	154.4	153.1	(1.3)
Дансны өглөг /ТӨҮГ/	18,702.1	15,850.1	(2,852.0)
Урьдчилж олсон орлого	3,958.3	2,170.8	(1,787.5)
Бусад урьдчилж олсон орлого	3,958.3	2,170.8	(1,787.5)
Урт хугацаат өр төлбөр	71,635.3	67,359.5	(4,275.8)
Урт хугацаат зээл	71,635.3	67,359.6	(4,275.7)
Дүн	107,361.9	100,799.2	(6,562.7)

Эх сурвалж: Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Нийт өр төлбөрийн үлдэгдлийн 95.3 хувийг төрийн өмчит үйлдвэрийн газрууд, 4.7 хувийг төсөвт байгууллагын өр төлбөр эзэлж байна. Тухайлбал: МХС ТӨХХК 72,437.0 сая төгрөг, МЦХ ХК 10,432.5 сая төгрөг, МШ ХК 9,702.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Өр төлбөр дансны бууралтад БНҮҮС-ийн 2,312.3 сая төгрөгийн урьдчилж олсон орлогыг тайлант оны орлогоор хүлээн зөвшөөрсөн, МХС ТӨХХК-ийн дамжуулан зээлдүүлэх зээлийн эргэн төлөлтөд 2,124.1 сая төгрөг, бусад урт хугацаат өр төлбөрт 2,218.9 сая төгрөг төлсөн нь голлон нөлөөлсөн байна.

Аудитын илрүүлэлт:

- Өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй нийт 250.4 сая төгрөг. /МШ ХК 238.4 сая төгрөг, МТҮП ТӨААТҮГ 6.0 сая төгрөг, МХС ТӨХХК 6.0 сая төгрөг/;
- Төсвийн хөрөнгийг зохистой удирдаагүйгээс өр төлбөр үүссэн нийт 401.2 сая төгрөг /ЦХИХХЯ 298.4 сая төгрөг, ТЦҮЗГ 102.8 сая төгрөг/;
- Анхан шатны шүүхийн шийдвэрээр сөрөг нэхэмжлэлийн төлбөрт төлөх 787.2 сая төгрөгийн өр төлбөрийг тайланд бүртгэж, тусгаагүй. /МТҮП ТӨААТҮГ/.

3.4.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 409,619.5 сая төгрөг болж, өмнөх оноос 7,610.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 10. Засгийн газрын хувь оролцоо

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал	6,863.5	6,863.5	-
Улсын төсвийн оруулсан хөрөнгө	6,863.5	6,863.5	-
Өмч төрийн /ТӨҮГ/	227,806.7	227,806.7	-
Нэмж төлөгдсөн капитал /ТӨҮГ/	2,538.5	2,538.5	-
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	80,018.6	81,527.1	1,508.5
Хуримтлагдсан үр дүн	41,818.3	49,392.1	7,573.8
Өмнөх үеийн үр дүн	36,994.4	41,833.5	4,839.1
Тайлант үеийн үр дүн	4,823.9	7,558.6	2,734.7
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	42,963.1	41,491.6	(1,471.5)
Дүн	402,008.7	409,619.5	7,610.8

Эх сурвалж: Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Засгийн газрын хувь оролцооны 82.3 хувь буюу 337,060.4 сая төгрөг нь ТӨҮГ-ын, 17.7 хувь буюу 72,559.1 сая төгрөг нь төсвийн байгууллагатай холбоотой байна. Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл өссөн нь хуримтлагдсан үр дүн болон эздийн өмчийн бусад хэсэг данстын өсөлтөөс голлон шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн ерөнхийлөн захирагчийн төлөвлөлт

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны төсвийн төсөлд нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс урсгал зардлыг 113,324.8 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлогоос санхүүжих 8,410.6 сая төгрөг, урьд оны үлдэгдлээс санхүүжих 3,145.7 сая төгрөг, хөрөнгийн зардлыг 142,015.7 сая төгрөг, нийт 266,896.8 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийн саналаас урсгал зардлыг 42,165.1 сая төгрөгөөр бууруулж, 82,716.0 сая төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 106,270.6 сая төгрөгөөр бууруулан 35,745.1 сая төгрөгөөр баталсан нь төсвийн төслийг бодитой боловсруулаагүйгээс шалтгаалсан байна.

Батлагдсан төсвөөс урсгал зардлыг 24,104.6 сая төгрөг, хөрөнгийн зардлыг 12,382.3 сая төгрөгөөр тус тус бууруулан тодотгож, 81,974.2 сая төгрөгөөр баталжээ.

3.5.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх “Мэдээллийн нэгдсэн тогтолцооны дэд бүтэц” хөтөлбөрийн 18 арга хэмжээг санхүүжүүлэхээр 81,974.2 сая төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр улсын төсвөөс 54,659.4 сая төгрөгийн санхүүжилт авч, 2,565.0 сая төгрөгийг буцаан төвлөрүүлж, улсын төсвөөс 52,094.9 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлогоос 11,277.9 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад 2025 оны 02/2319 тоот албан бичгээр төсвийн зохицуулалт хийх хүсэлтийг хүргүүлсэн ч төсвийн хуваарьт өөрчлөлт оруулаагүй байна.

Улсын төсвийн орлого бүрдүүлэлт

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулиар Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг 8,663.3 сая төгрөгөөр баталснаас, 16,122.8 сая төгрөгийг бүрдүүлж, төлөвлөснөөс 86.1 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт 11. Улсын төсөвт төвлөрүүлэх орлого

/сая төгрөгөөр/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Улсын төсөвт төвлөрүүлэх орлого	3,500.0	8,490.8	4,990.8	142.6
Бүх нийтийн үйлчилгээний сангийн орлого	5,163.3	7,632.0	2,468.7	47.8
Нийт дүн	8,663.3	16,122.8	7,459.5	86.1

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 63,372.3 сая төгрөг буюу 77.3 хувьтай байгаа нь олон улсын байгууллагын гишүүнчлэлийн байгууллагын хураамж /80509/ арга хэмжээнээс 463.5 сая төгрөг, цахим шилжилт /80316/ арга хэмжээнээс 630.4 сая төгрөг, алслагдсан орон нутагт хүргэх үйлчилгээ /81538/ хөрөнгө оруулалтын зардлаас 1,778.7 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны зардлаас /80101/ 3,796.9 сая төгрөг, хөрөнгө оруулалтын зардлаас 11,372.8 сая төгрөгийг тус тус дутуу зарцуулснаас голлон шалтгаалжээ.

Хүснэгт 12. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71302-Мэдээлэл технологийн нэгдсэн дэд бүтэц	81,974.2	63,372.3	18,601.9	77.3
1.1	80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	36,927.8	33,130.9	3,796.9	89.7
1.2	80103-Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	62.8	62.1	0.7	98.9
1.3	80205-Мэдээлэл, сурталчилгааны зардал	14.1	12.1	2.0	85.8
1.4	80220-Холбооны суваг ашигласны хөлс	100.7	100.7	0.0	100.0
1.5	80226-Байр ашиглалтын үйлчилгээ	281.4	193.1	88.3	68.6
1.6	80307-Шүүхийн шийдвэрийн дагуу олгох	17.6	15.8	1.8	89.8
1.7	80316-Цахим шилжилт арга хэмжээ	2,453.4	1,823.0	630.4	74.3
1.8	80509-Олон улсын байгууллагын гишүүнчлэлийн хураамж	2,146.7	1,683.2	463.5	78.4
1.9	80704-Ахмад дайчин, алдар цолтой ахмад	85.1	64.8	20.3	76.1
1.10	80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж	62.4	14.1	48.3	22.6
1.11	80918-Бусад	23,362.8	11,990.0	11,372.8	51.3
1.12	81520-Олон улсын хурал, зөвлөгөөн зохион байгуулах	212.5	127.6	84.9	60.0
1.13	81538-Алслагдсан орон нутагт хүргэх	8,045.7	6,266.9	1,778.8	77.9
1.14	81569-Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх	1,099.8	863.2	236.6	78.5
1.14	81805-Инновац, өндөр технологи	546.4	469.8	76.6	86.0
1.15	82402-INTELSAT ба REUTERS-ийн суваг	1,346.9	1,346.9	0.0	100.0
1.16	82403-Радио шугам, хиймэл дагуул, VP	5,208.1	5,208.1	0.0	100.0

Судалгааны үр дүн: Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу аудитын явцад дараах зардлын судалгааг авч, үр дүнг дүгнэлээ.

Монгол Улсын хөгжлийн 2026 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэлийн “Төрийн албаны шинэчлэлийг хийж, чиг үүргийн давхардлыг арилгах зорилгоор багш, эмч нараас бусад төрийн албан хаагчдын тоог 9 хувиар бууруулах замаар чадварлаг, цомхон, бүтээмжид суурилсан төрийн албыг бэхжүүлнэ” гэж заасны дагуу 2025 оны төсвийн тодотголоор харьяа байгууллагуудын орон тоо, цалингийн санг бууруулан тодотгосон байна. Орон тоог бууруулсан байгууллагуудыг жагсаавал:

- ЦХИХХЯ батлагдсан орон тоог 89 болгон удирдах 7, гүйцэтгэх 2 орон тоо,
- ТЦҮЗГ орон тоог 158 болгон үйлчилгээний 16 орон тоо,
- ҮДТ УТҮГ орон тоог 76 болгон гүйцэтгэх 8 орон тоо,
- РТҮС УТҮГ орон тоог 215 болгон удирдах 5, гүйцэтгэх 6, үйлчлэх 2 орон тоо,
- КХЗТНТ УТҮГ орон тоог 47 болгон гүйцэтгэх 5 орон тоо,
- МТҮП ТӨААТҮГ орон тоог 43 болгон 1 удирдах, 10 гүйцэтгэх, 1 үйлчлэх орон тоог тус тус бууруулсан байна.

И-Монгол академи УТҮГ, КАБЗАА, МХС ТӨХХК, МЦХ ХК нь бүтэц, орон тоог бууруулан батлаагүй ч сул орон тоотой ажиллаж байна.

ЦХИХХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын хоол, унааны зардлыг захирлын тушаал, төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын тогтоол, хөдөлмөрийн дотоод журам, үйлдвэрчний эвлэлийн хамтын гэрээнд тусгасны дагуу ажлын нэг өдөрт олгох дүнг задлан харуулбал:

- ЦХИХХЯ 40.0 мянган төгрөг, КАБЗАА 38.0 мянган төгрөг, ТЦҮЗГ 33.0 мянган төгрөг,
- КХЗТНТ УТҮГ 37.0 мянган төгрөг, РТҮС УТҮГ 25.0 мянган төгрөг, И-Монгол академи УТҮГ 25.0 мянган төгрөг, ҮДТ УТҮГ 21.0 мянган төгрөг, МХС ТӨХХК 10.5 мянган төгрөг, МТҮП ТӨААТҮГ 9.0 мянган төгрөг, МЦХ ХК 3.0 мянган төгрөг, МШ ХК 2.0 мянган төгрөг.

Гадаад томилолтын зардлаас тайланд онд төрийн өмчит үйлдвэрийн газрууд 562.6 сая төгрөгийн 56 арга хэмжээ, ЦХИХХЯ 138.7 сая төгрөгийн 10 арга хэмжээ төлөвлөснөөс эрх

бүхий этгээдийн тушаал шийдвэртэйгээр төрийн өмчит үйлдвэрийн газрууд 465.6 сая төгрөгийн 56, ЦХИХХЯ 29.3 сая төгрөгийн 6 арга хэмжээг тус тус хэрэгжүүлсэн байна.

ЦХИХХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд 18,874.1 сая төгрөгийн програм хангамж, лицензүүд ашиглаж байгаагаас 17,303.5 сая төгрөгийн програм хангамж, лицензүүд нь санхүүгийн тайланд бүртгэлтэй, 1,570.6 сая төгрөгийн програм хангамж, лицензүүд бүртгэлгүй, 18,722.6 сая төгрөгийн хөрөнгийг ашиглаж байгаа, 151.5 сая төгрөгийн хөрөнгийг ашиглахгүй байна.

Хурал зөвлөгөөн, сургалтад хамрагдахаар төрийн өмчит үйлдвэрийн газрууд 818.2 сая төгрөгийн 90 арга хэмжээ, төсвийн байгууллагууд 393.4 сая төгрөгийн 16 арга хэмжээ төлөвлөснөөс эрх бүхий этгээдээс баталсан шийдвэртэйгээр төрийн өмчит үйлдвэрийн газрууд 693.2 сая төгрөгийн 74, төсвийн байгууллагууд 393.4 сая төгрөгийн 16, төсөвт батлагдаагүй 605.0 сая төгрөгийн 2 арга хэмжээг тус тус хэрэгжүүлсэн байна.

ЦХИХХЯ нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2025 оны 09 дүгээр сарын 128/ШШ2025/0597, 128/ШШ2025/0621 дугаартай шийдвэрүүдээр буруутай албан тушаалтны шийдвэрээр ажлаас чөлөөлөгдсөн 2 ажилтны ажилгүй байх хугацааны нөхөн олговорт 15.8 сая төгрөг олгосон байна.

ЦХИХХЯ Цахимаар түрүүнд /Digital first/ үйл ажиллагааны талаар контент хийлгэх, хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд сурталчлахад 94.9 сая төгрөг, МШ ХК цахим маркетинг хийлгэх ажилд 12.8 сая төгрөг, МТҮП ТӨААТҮГ Tech week-2025 арга хэмжээг олон нийтэд түгээхэд 11.0 сая төгрөг, И-Монгол академи УТҮГ цахим шилжилтийн мэдээлэл зөвлөмж олон нийтэд хүргэхэд 6.7 сая төгрөгийн зардал тус тус гаргасан байна.

Төрийн өмчит үйлдвэрийн газруудын хувьд:

Төрийн болон орон нутгийн эзэмшлийн хувь нь харьяалах төсвийн ерөнхийлөн захирагчийн 100 хувийн эзэмшилтэй УДТ УТҮГ, РТҮС УТҮГ, төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 100 хувийн эзэмшилтэй МТҮП ТӨААТҮГ, 94.7 хувийн эзэмшилтэй МЦХ ХК, 66 хувийн эзэмшилтэй МШ ХК, Эрчис монголын 100 хувийн эзэмшилтэй МХС ТӨХХК байгууллагууд байна.

ЦХИХХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагад 8 төрийн өмчит үйлдвэрийн газар харьяалагдаж байгаагаас 4 УТҮГ байна. Тайлант онд 4 ТӨААН-үүдийн эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшинг ашигтай ажиллахаар батлагдсанаас гүйцэтгэлээр МХС ТӨХХК 3,336.7 сая төгрөг, МШ ХК 180.0 сая төгрөг, МТҮП ТӨААТҮГ 90.7 сая төгрөг, МЦХ ХК 8.2 сая төгрөгийн тус тус ашигтай ажилласан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын багцын 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд ерөнхий гэрээгээр 134.0 сая төгрөг, нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 25,862.6 сая төгрөг, харьцуулалтын аргаар 3,097.3 сая төгрөг, шууд худалдан авалтын аргаар 3,227.3 сая төгрөг, нийт 32,321.2 сая төгрөгийн худалдан авалтыг зохион байгуулахаар тусгасан байна. Үүнд,

- Зээл, тусламжаас 85.9 сая төгрөг,
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 9,222.9 сая төгрөг,
- Урсгал төсвөөс 23,012.4 сая төгрөг.

Гүйцэтгэлээр нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 20,344.5 сая төгрөгийн худалдан авалтаар үүрэн холбооны сүлжээ дэд бүтэц барих, цахим шилжилтийн тоног төхөөрөмж, лиценз, харьцуулалтын аргаар 1,736.6 сая төгрөгийн худалдан авалт, ерөнхий гэрээгээр 21.8 сая төгрөгийн лиценз, шууд худалдан авалтын аргаар 2,692.8 сая төгрөгийн бараа, ажил, нийт 24,795.7 сая төгрөгийн бараа, үйлчилгээ, хөрөнгийн худалдан авалтыг зохион байгуулсан байна.

Аудитын илрүүлэлт:

- Худалдан авах ажиллагааг хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулаагүй нийт 310.0 сая төгрөг /БНҮҮС 232.4 сая төгрөг, РТҮС УТҮГ 77.6 сая төгрөг /.

3.5.4 Хөтөлбөр арга хэмжээний хүрэх үр дүн, хэрэгжилт

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн нэгдүгээр хавсралтаар баталсан Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд 4 хөтөлбөрийн 11 арга хэмжээний зорилтот түвшнийг тусгасан бөгөөд ЦХИХХЯ-ны ХШҮДАГ-аас хэрэгжилтийг 81.8 хувиар үнэлсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт					Зорилтот түвшин	Үр дүн
Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд						
71302 Мэдээллийн нэгдсэн тогтолцооны дэд бүтэц						
36.1	36.1.1	Зөв засаглалын үзүүлэлтээр эхний 100 орны нэг болно.	36.1.1.1	Цахим хэлбэрт шилжүүлсэн үйлчилгээний тоо	1200	1268
			36.1.1.2	Албан бичиг солилцооны дундын системд байгууллагыг холбох	1800	3058
			36.1.1.3	Тоон гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлэх	1131	1738
			36.1.1.4	Төрийн мэдээлэл солилцооны "ХУР" системд төрийн байгууллагыг холбох	140	190
			36.1.1.5	Төрийн мэдээлэл солилцооны "ХУР" системд хувийн хэвшлийн байгууллагыг холбох	350	534
			36.1.1.6	Төрийн үйлчилгээнд дахин загварчлал хийсэн байгууллага	1	1
	36.1.2	Бизнес эрхлэхэд таатай 93 орны нэг болно.	36.1.2.1	Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсийн ажлын албаны үйл ажиллагааны платформ хөгжүүлэх	1	1
			36.1.2.2	Мэдээллийн технологийн үйлдвэрлэлээс төсөвт төвлөрүүлсэн орлогын талаарх болон салбарын зах зээл, хөрөнгө оруулалтын талаарх үүсгэсэн статистик мэдээллийн өгөгдлийн сан	1	-
			36.1.2.3	Мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хүн, хуулийн этгээдээс худалдан авах нэг цонхны бүртгэлийн системийн хэвийн үйл ажиллагааг ханган ажиллах-Mindgolia.mn	1	-
	36.1.3	Инновацын тогтолцооны хөгжлөөр эхний 85 орны нэг болно.	36.1.3.1	Өндөр технологи, инновац бизнес хөгжлийн төв байгуулах	1	1
	36.1.4	Үүрэн холбооны хөдөлгөөнт өргөн зурвасын хэрэглэгчийн тоог нэмэгдүүлнэ.	36.1.4.1	Алслагдсан бүс нутагт хөдөлгөөнт холбооны үйлчилгээ хүргэх	29	40

Тайлант хугацаанд хэрэгжээгүй дараах хөтөлбөр арга хэмжээ байна. Үүнд:

- Салбарын хяналт шинжилгээ-үнэлгээ дотоод аудитын газраас хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 36.1.3.1-д “Өндөр

технологи, инновац бизнес хөгжлийн төв байгуулах” арга хэмжээг биелснээр үнэлсэн боловч тухайн төв байгуулагдаагүй;

- Мэдээллийн технологийн салбарын үйлдвэрлэгчдийн бүртгэлийн нэгдсэн платформ хөгжүүлэн мэдээллийн сан үүсгэж, статистик мэдээллийн дашбоард хөгжүүлэх зорилгоор “Мэдээллийн технологийн салбарын үйлдвэрлэгчдийн бүртгэлийн нэгдсэн платформ хөгжүүлэх” худалдан авах ажиллагааг 2025 онд төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр 2 удаа зарласан боловч шаардлагад нийцсэн тендер ирээгүй;
- “Мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хүн, хуулийн этгээдээс худалдан авах нэг цонхны бүртгэлийн системийн хэвийн үйл ажиллагааг ханган ажиллах /Mindgolia.mn/” арга хэмжээний техникийн нөхцөл, шаардлага, заавар аргачлалыг боловсруулах суурь судалгааг хийж гүйцэтгэсэн боловч төсвийн тодотголоор төсөв танагдсантай холбоотойгоор хэрэгжээгүй;

Төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг төлөвлөхдөө зорилтот түвшинг үнэн зөв бодитой төлөвлөдөггүй өмнөх оны зорилтот түвшинг өөрчлөөгүй, хэрэгжих боломжтой арга хэмжээг тусгадаггүй зэргээс төсвийн зардлын гүйцэтгэл, арга хэмжээний зорилтот түвшний үзүүлэлтийн биелэлт уялдахгүй, үр дүнг үнэлэх боломжгүй байна.

3.5.5 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 885.4 сая төгрөг, Засаг даргын нөөц хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 137.7 сая төгрөг, төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламжийн 40.9 сая төгрөг, нийт 1,064.0 сая төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна. Тухайлбал:

- ҮДТ УТҮГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд Сангийн сайдын 2022 оны А/30 тушаалаар батлагдсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”-ыг үндэслэн 740.5 сая төгрөг;
- ТЦҮЗГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд НҮБ-аас (DEMOSC) төслийн хүрээнд 102.7 сая төгрөг, орон нутгийн ажилчдад “Нутгийн дэм” 113.8 сая төгрөг, өмнөх оны татаас санхүүжилтийн авлагаас 23.9 сая төгрөг, нийт 240.4 сая төгрөг;
- И-Монгол академи УТҮГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон 117.1 сая төгрөг;

Гүйцэтгэлээр 946.7 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 117.3 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. Үүнээс бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 581.9 сая төгрөг, мэдээлэл технологийн үйлчилгээний зардалд 191.1 сая төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд 118.4 сая төгрөг, цалин хөлсний зардалд 19.3 сая төгрөг, багаж техник хэрэгслийн зардалд 19.1 сая төгрөг, дотоод томилолтын зардалд 16.9 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн төсвийн ерөнхийлөн захирагч, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Үндэсний аудитын газрын Санхүү, нийцлийн аудитын газрын аудитор Т.Баасанцэнд, аудитор Г.Тэлмүүн нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер П.Чанцалдулам, газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Баярсайхан нар тус тус хэрэгжүүлсэн.

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 04 дүгээр сарын 03-ний өдрийн 02/556 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-д заасны дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 102,170.0 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 1,021.7 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Тайлант оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангаар нийт зардал 113,006.3 сая төгрөг болж, өмнөх оноос 10.6 хувиар өссөн нь нөлөө бүхий өөрчлөлт гэж үзсэн.

Материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 113,006.3 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 1,130.1 сая төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хуваарилагдсан төсвийг үр өгөөжтэй, хэмнэлттэй зарцуулах, хуульд тусгагдсан хэмнэлтийн горим, бусад арга хэмжээг үйл ажиллагаандаа мөрдлөг болгоход анхаарч ажилласан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой дараах зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчсөн болон өмнөх оны аудитын зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй нийт 301.1 сая төгрөг /ЦХИХХЯ 256.8 сая төгрөг, ТЦҮЗГ 40.5 сая төгрөг, МТҮП ТӨААТҮГ 3.8 сая төгрөг/.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй харьяа байгууллага МТҮП ТӨААТҮГ-т 198.1 сая төгрөгийн зөвлөмж өгсөн байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан нийцлийн аудитаар нийт 762.8 сая төгрөгийн 27 зөрчил илэрснээс 564.7 сая төгрөгийн зөрчилд 8 албан шаардлага хүргүүлж, 198.1 сая төгрөгийн зөрчилд 18 зөвлөмж өгч, хариуцлага тооцуулах 1 албан шаардлага хүргүүлсэн байна.

Аудитын илрүүлэлт:

- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэлийг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулаагүй нийт 549.9 сая төгрөг/ ТЦҮЗГ 549.9 сая төгрөг, ЦХИХХЯ, БНҮҮС, МЦХ ХК/;
- Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг хуулийн хугацаанд нь ирүүлээгүй /ТЦҮЗГ, МШ ХК/;
- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй / ЦХИХХЯ/;
- Салбарын хяналт хэрэгжүүлдэг улсын байцаагчдын хөдөлмөр хамгааллын хэрэгслийн нэр төрөл, эдэлгээний хугацаа бүхий жагсаалтыг баталж мөрдүүлээгүй нь хөдөлмөр хамгааллын хэрэгслийн төсөвт өртөг, гүйцэтгэлийг үнэлэх боломжгүй. / ЦХИХХЯ/;
- Монгол Улсын засгийн газрын тухай хуульд Эдийн засаг, хөгжлийн сайдад шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн асуудлыг хамааруулсан боловч Цахим хөгжил, инновац харилцаа холбооны сайдад үндэсний инновацийн тогтолцооны бодлого төлөвлөлт хөгжүүлэх асуудлыг хамааруулсан нь харилцаа холбоо, мэдээллийн технологи хариуцсан чиглэлийн яамны чиг үүрэгтэй нийцэхгүй, салбарын бодлого хоорондын уялдаа хангагдахгүй байх, үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэхэд салбарын мэргэжилтнүүд байхгүйгээс хуулийн хэрэгжилт хангагдахгүй, үр ашиггүй зардлууд гарах эрсдэлтэй. / ЦХИХХЯ /;
- Бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт, сул орон тоог нөхөх зохицуулалтыг хэрэгжүүлж ажиллаагүйгээс яамны үндсэн чиг үүрэг, үйл ажиллагааны тогтвортой байдал алдагдах, хүний нөөцийн чадавх сулрах эрсдэлтэй. / ЦХИХХЯ /;
- Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ болон төсвийн тухай хуулийн 1-р хавсралтад тусгагдсан хэрэгжүүлэх хөтөлбөрүүд нь хоорондоо уялдахгүй байгаа нь шаардлагагүй төсвийн зарцуулалт гаргах эрсдэлтэйб / ЦХИХХЯ /;
- ТУЗ-ийн 2024 оны 12 дугаар сарын 209 дүгээр хурлаар баталсан 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний орлогын төлөвлөгөөг тасалсан. /МЦХ ХК/;
- Сонгон шалгаруулалт зохион байгуулахгүйгээр "Бараа борлуулах гэрээ" нэртэй гэрээгээр нийлүүлэгчээс төхөөрөмж авч, хэрэглэгчид түгээсэн болон төлбөр орж ирсэн эсэхийг баталгаажуулалгүйгээр үнийг бүрэн төлсөн. Үүнд: Дэлгэрэх билэг ХХК-д 49.5 сая төгрөг, Гүн цэнхэр огторгуй ХХК-д 82.5 сая төгрөг, Нанар ХХК-д 150.0 сая төгрөгийг тус тус шилжүүлсэн. /МЦХ ХК/;
- Байгууллага нь ахмадын сангийн журамгүйгээр ахмадуудад хүндэтгэл үзүүлэх, буцалтгүй тусламж, тэтгэмж олгоход зарцуулсан.
- Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 722 дугаар тогтоолоор баталсан "2025 оны бизнес төлөвлөгөөний эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө"-нөөс авлагыг 8,109.2 сая төгрөгөөр, өглөгийг 1,399.9 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн. / МХС ТӨХХК/;
- Шалгагдагч байгууллагуудын орон нутгийн газруудын улсын бүртгэлийн гэрчилгээнд тухайн аймгийн салбар нэрээр бүртгэгдсэн ба албан ёсны хэвлэмэл хуудсанд Газар нэртэй байна. / МХС ТӨХХК/;
- Компани нь том 5 хувьцаа эзэмшигчийн нэг болох Ард кредит ББСБ ХХК-тай 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдөр ХИУГ/2045 дугаартай гэрээ байгуулж, 1.0 сая ам.долларыг 6 сарын хугацаатай, жилийн 4 хувийн хүүтэй хадгалуулсан. Ард кредит ББСБ нь тус хадгаламжийн гэрээний хугацаа дууссан өдөр мөнгийг буцааж шилжүүлээгүй, 10 дугаар сарын 01-ний өдрөөс дахин 6 сараар сунгасан нь эргэн төлөгдөхөд эрсдэл учирч болзошгүй байна. / МШ ХК/;

- *Төвийн захирлын 2025 оны Б/22 дугаар тушаалаар байгууллагын дүрэмд тусгаагүй 6.5.15, 6.2.1, 6.2.6 тус заалтуудыг үндэслэн ажилтанд 2024 оны 2 дугаар сараас 1 жилийн хугацаатай цалинтай чөлөө олгосон. / ҮДТ УТҮГ/.*

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай болон бусад хууль тогтоомжийн хүрээнд холбогдох хуулийн заалт, шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

Төсвийн ерөнхийлөн захирагч:

4.4.2.1 Албан шаардлага

Илрүүлэлт 1: Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2024 оны А/53 дугаар тушаалаар Кибер аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албаны үндсэн цалингийн хэмжээг 2.5-5.5 сая төгрөгөөр тогтоосон нь хууль эрх зүйн үндэслэлгүй байна.

Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2024 оны "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 238 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт "Монгол Улсын Их Хуралд ажлаа хариуцан тайлагнадаг зарим байгууллагын ажлын алба болон адилтгах бусад байгууллага, зөвлөлийн ажлын албаны албан тушаалын цалингийн хэмжээ" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ажлын албаны үндсэн цалингийн хэмжээг тогтоох эрхгүй албан тушаалтан ажлын албаны цалин тогтоосон зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа түүврийн байгууллагууд:

4.4.2.2 Албан шаардлага

Илрүүлэлт 1: Кибер аюулгүй байдлын зөвлөлийн ажлын алба нь Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2024 оны А/53 дугаар тушаалаар үндсэн цалингийн хэмжээг 2.5-5.5 сая төгрөгөөр тогтоосон нь Монгол Улсын Засгийн газрын 2024 оны "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 238 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтад зааснаас 1.0-2.8 сая төгрөгөөр илүү байна.

Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2024 оны "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 238 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт-д "Монгол Улсын Их Хуралд ажлаа хариуцан тайлагнадаг зарим байгууллагын ажлын алба болон адилтгах бусад байгууллага, зөвлөлийн ажлын албаны албан тушаалын цалингийн хэмжээ" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоолоор ажлын албаны албан хаагчдын албан тушаалын цалингийн хэмжээг тогтоох албан шаардлага хүргүүлэв.

4.4.2.3 Зөвлөмж

Илрүүлэлт 1: Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа төсөл арга, хэмжээний худалдан авах гэрээ байгуулах, хэрэгжилтийг тайлагнахтай холбоотой дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Хөдөөгийн алслагдсан багуудын харилцаа холбооны дэд бүтэц /улсын хэмжээнд/ хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг 13 багцад хуваан зарлаж, 9 багцын гүйцэтгэгчтэй байгуулсан худалдан авах гэрээнд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэх этгээдийг тусгаж өгөөгүй;
- "Файбер оптик констракшн" ХХК-тай 2024 онд байгуулсан УТ2406700144005 гэрээний тусгай нөхцөлд захиалагчийг төлөөлөн гүйцэтгэгчтэй харилцах, хяналт тавих төлөөлөгч нь Баян-Өлгий аймгийн газрын харилцаа, барилга хот

байгуулалтын газар байна." гэж заасан боловч захиалагчийн хяналтыг хэрэгжүүлээгүй,

- "Файбер оптик констракшн" ХХК, Иррадианс ХХК-ийн гүйцэтгэсэн ажлын захиалагчийн хяналтыг хийлгэхээр Грэвинг валю ХХК-тай 17.6 сая төгрөгийн гэрээ байгуулж, 14.8 сая төгрөгийг шилжүүлсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.3-т "Худалдан авах гэрээнд дараах нөхцөлийг тусгана: " 39.3.5-д "захиалагчийн хяналт хэрэгжүүлэх этгээд, хэлбэр,"; ЦХИХХЯ болон Файбер оптик констракшн ХХК-тай байгуулсан 2024 оны 12 сарын 18-ны өдрийн УТ2406700144005 гэрээний ГЕН 2.4 дэх, ЦХИХХЯ болон Иррадианс ХХК-тай байгуулсан 2024 оны 04 сарын 22-ны өдрийн УТ2406700144010 гэрээний ГЕН 2.4 дэх заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Худалдан авах ажиллагааны гэрээг байгуулахдаа хуульд заасны дагуу захиалагчийн хяналт хэрэгжүүлэх этгээд, хэлбэрийг тусгаж байх, гэрээнд тусгагдсан этгээдээр хяналтыг хийлгэж, санхүүжилтийг олгож байх.

Илрүүлэлт 2: Төсвийн ерөнхийлөн захирагчийн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний төсвийн төслийн саналыг улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, төсвийн хязгаартай уялдуулан боловсруулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.4-т "жилийн төсвийн хязгаарт үндэслэсэн байх,"; 27.1.8-д "Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд суурилсан байх,"; Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журмын 2.2.2-т "Төсөл, арга хэмжээний саналд энэ журамд заасны дагуу судалгаа хийж, эрэмбэлэн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх нэн тэргүүний ач холбогдолтой төсөл, арга хэмжээнүүдийг тодорхойлох, жагсаалт гаргах,"; 2.2.14-т "Тухайн жилийн төсвийн тухай хуулиар өөрийн багцад батлагдсан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг хангаж ажиллах,"; Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10.3-т "улсын төсөв нь Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх," гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төсвийн төслийн саналыг улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдуулан төлөвлөж байх

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

ЦХИХХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын аудитаар эхний хагас жилийн баталгаажсан санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийж, төсвийн ерөнхийлөн захирагч, түүний орчин, дотоод хяналт, дотоод аудитын талаар ойлголт олж аван эрсдэл тодорхойлж, аудитын ерөнхий стратеги боловсруулан ажилласан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн 1 албан шаардлага, 1 зөвлөмж, түүврийн байгууллагад тогтоосон 1 төлбөрийн акт, хүргүүлсэн 10 албан шаардлага, өгсөн 11 зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлэхэд нийт биелэлт 99.7 хувьтай байна.

Хүснэгт 13. Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төсвийн шууд захирагч					
Төлбөрийн акт	1	13,379.2	1	13,379.2	100.0
Албан шаардлага	10	18,476,951.9	10	18,476,951.9	100.0
Зөвлөмж	11	27,187,726.8	10	27,109,726.8	99.7

Төсвийн ерөнхийлөн захирагч					
Албан шаардлага	1	-	1	-	100.0
Зөвлөмж	1	-	1	-	100.0
Нийт дүн	24	45,678,057.9	24	45,600,057.9	99.7

Өмнөх аудитаар өгсөн төсвийн төсөлд тусгагдаагүй ажил, үйлчилгээг санхүүжүүлэхгүй байх зөвлөмжийн хэрэгжүүлж ажиллаагүй, И-Монгол академи УТҮГ-т албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

ЦХИХХС-ын 2024-2026 онд шилжин хэрэгжих хөдөөгийн алслагдсан багуудын харилцаа холбооны дэд бүтэц /улсын хэмжээнд/ хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнд техник эдийн засгийн үндэслэлгүйгээр 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулиар батлагдаж, худалдан авах ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэгч шалгарч гэрээ байгуулсны дараа техник эдийн засгийн үзүүлэлт батлагджээ. Үүнээс шалтгаалан хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төсөвт өртөг нэмэгдэх, гэрээ байгуулсан гүйцэтгэгчээс гэрээ цуцлах нөхцөл байдлаас үүсэх эрсдэлийг төсвийн ерөнхийлөн захирагчийн дараагийн аудитаар үзэх шаардлагатай гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 4,914.1 сая төгрөгийн 20 алдаа¹ илэрснээс аудитын явцад 4,893.0 сая төгрөгийн 18 алдааг залруулж, 21.1 сая төгрөгийн алдааг дахин давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгсөн.

МХС ТӨХХК-ийн залруулаагүй алдаа:

- Байгууллагын бараа материалын дансанд бүртгэлтэй Магнайтрейд ХХК-ийн шатахууны талоны үлдэгдлээс 198.0 сая төгрөгийн талоныг ажилчдад борлуулахдаа, татвар ногдуулах орлогоос хасагдахгүй зардлаар тайлагнасны улмаас Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын зардлыг Санхүүгийн тайлан болон татварын ТТ02 тайланд 19.8 сая төгрөгөөр илүү тайлагнасан нь НББОУС12 Орлогын албан татвар 5-д "Татвар ногдуулах ашиг (татварын алдагдал) гэдэг нь татварын эрх бүхий байгууллагаас гаргасан дүрэм журмын дагуу тодорхойлсон тухайн тайлант хугацааны ашиг (алдагдал) бөгөөд үүнд үндэслэн татварыг өглөгийг (буцаан олгох татварыг) тооцоолдог" гэсэнтэй нийцэхгүй, Санхүүгийн тайлагналын үнэн зөв байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.
- Тайлант онд 9 дүгээр сард 1 ажилтны цалин хөлсийг Нийгмийн даатгалын цахим тайланд тайлагнахдаа 1.3 сая төгрөгөөр дутуу тайлагнасан нь НББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга 15-д "Санхүүгийн тайланд аж ахуйн нэгжийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой. Үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээ, бусад үйл явдал ба нөхцөл байдлуудын үр нөлөөг Санхүүгийн Тайлагналын Онолын Үзэл Баримтлалд заан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодорхойлолт болон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурт нийцүүлэн үнэн зөв илэрхийлэхийг шаарддаг..." гэсэнтэй нийцэхгүй, Санхүүгийн тайлагналын үнэн зөв байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Залруулсан алдаа:

-УСНББОУС-1-ийн 27-д "Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой. Үнэн зөв толилуулга ажил гүйлгээ, бусад үйл явдал ба нөхцөл байдлуудыг үзэл баримтлалд заасан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодорхойлолт болон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурт нийцүүлэн үнэн зөв илэрхийлэхийг шаарддаг",

-НББОУС-8 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт ба алдаа стандартын 41-д "...тайлант үед илрүүлсэн уг тайлант үеийн боломжит алдааг тухайн үеийн тайланг гаргахыг зөвшөөрөхөөс өмнө засварладаг..." гэж заасны санхүүгийн тайлангийн толилуулгын батламж мэдэгдлийг хангаагүй дээрх алдааг аудитын явцад бүрэн залруулсан.

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 13 төсвийн байгууллага, төрийн өмчит аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс "Хязгаарлалттай" 7, "Өөрчлөлтгүй" 2 санал дүгнэлт өгч, 3 байгууллага түүвэрт хамрагдсан. Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сан тайлант онд гүйцэтгэл гараагүй байна.

Аудитаар нийт 5,522.8 сая төгрөгийн 70 зөрчил² илэрснээс, 80.8 сая төгрөгийн зөрчилд 14 төлбөрийн акт тогтоож, 3,893.7 сая төгрөгийн зөрчилд 42 албан шаардлага хүргүүлж, 1,393.0 сая төгрөгийн зөрчилд 12 зөвлөмж, 155.3 сая төгрөгийн зөрчилд хариуцлага тооцуулах 2 албан шаардлага хүргүүлсэн.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангаар илэрсэн нийт 5,543.9 сая төгрөгийн залруулагдаагүй нийт зөрчил нь

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 4,413.8 сая төгрөгөөр давсан тул “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгсөн.

5.1 Төсвийн ерөнхийлөн захирагчийн аудитаар илэрсэн алдаа, зөрчил:

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар 1 албан шаардлага хүргүүлсэн.

5.1.1 Албан шаардлага

Илрүүлэлт 1: ЦХИХХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар 5,543.9 сая төгрөгийн 71 зөрчил илэрснээс 80.8 сая төгрөгийн зөрчилд 14 төлбөрийн акт тогтоож, 3,893.7 сая төгрөгийн зөрчилд 41 албан шаардлага хүргүүлж, 1,414.1 сая төгрөгийн зөрчилд 14 зөвлөмж, 155.3 сая төгрөгийн зөрчилд хариуцлага тооцуулах 2 албан шаардлага өгсөн байна. Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлөөс 1,278.3 сая төгрөгөөр өссөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т "Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:", 14.2.10-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх.", 69 дүгээр зүйлийн 69.3-т "Дотоод аудитад төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагааг хамаарна." гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдаагүй алдаа, зөрчлийн арилган, дотоод хяналтыг сайжруулах албан шаардлага хүргүүлэв.

5.2 Түүврийн байгууллагын аудитаар илэрсэн алдаа, зөрчил:

5.2.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт 1: Тапатрип эжинси ХХК-д 2024 онд шилжүүлж, урьдчилгаа дансанд бүртгэсэн боловч 2025 оны санхүүгийн байдлын тайланд үлдэгдлээр тайлагнасан 1.3 сая төгрөгийн онгоцны тийзийн төлбөрийг улсын төсөвт төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;”, 6 дугаар зүйлийн 6.2.5-д "төсвийн жилийн дундуур орлого бууруулах, зарлага нэмэгдүүлэх үр дагавартай бодлогын аливаа шийдвэр гаргасан бол түүнийг дараагийн төсвийн жилээс хэрэгжүүлдэг байх;”, 41 дүгээр зүйлийн 41.2.3-т “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, 43 дугаар зүйлийн 43.1-д “Тухайн төсвийн жилд ашиглагдаагүй төсвийн дараах үлдэгдлийг төсвийн дараагийн жилд үргэлжлүүлэн зарцуулж болно:”, 43.1.1-д “Засгийн газрын өрийн бичиг, зээлийн үндсэн болон хүүгийн төлбөр”, 43.1.3-д “Улсын Их Хурлаас соёрхон баталсан, Засгийн газар хоорондын гэрээгээр болон олон улсын байгууллагын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төсөв”, 43.1.5-д “төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан тусламж, хандив.”, 45 дугаар зүйлийн 45.2-т “Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ:”, 45.2.1-д “нэгжид ногдох норм, нормативаар тооцон төсвийг нь баталсан ба гүйцэтгэл нь анх тооцсон нэгжийн тоо хэмжээнээс бага бол;”, 45.2.2-т “төлөвлөсөн төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйн улмаас, эсхүл тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдэгдэл;”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “үр ашигтай байх;”, 4.1.6-д “сахилга баттай байх;”, 4.1.9-д “хариуцлагатай байх;” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт төвлөрүүлээгүй 1.3 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2.2 Албан шаардлага

Илрүүлэлт 1: Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв УТҮГ-ын албан тушаалын тодорхойлолтод заагдсан үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэн ажилласан ерөнхий нягтлан бодогчид 1 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний 2.8 сая төгрөг, няравт 1.0 сая төгрөгийн урамшууллыг тус улсын төсөвт үйлдвэрийн газрын захирлын А/36 тоот тушаалаар олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ:”, 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;”, 23 дугаар зүйлийн 23.2-т “Нягтлан бодох бүртгэлийн ажилд үр бүтээл гарган ажилласан нягтлан бодох бүртгэлийн ажилтныг шагнаж урамшуулж болно.” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан тушаалын тодорхойлолтод заагдсан үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэн ажилласан санхүүгийн албан хаагчдад балансын урамшуулал олгосон зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 2: Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв УТҮГ-ын анхан шатны баримтаар дэмжигдэхгүй, улсын бүртгэлийн гэрчилгээнд бүртгэлтэй үйл ажиллагааны чиглэл таарахгүй аж ахуйн нэгж рүү 34.1 сая төгрөгийг шилжүүлсэн нь бодит бус ажил гүйлгээ хийх эрсдэлтэй, байгууллагын дотоод хяналт сул байна. Үүнд:

- Албан хаагчдад "Төрийн албан хаагчийн ёс зүйн сургалт" авахад “Дэл овоот” ХХК-д 4.8 сая төгрөг;
- CII summit 2025 уулзалт, зөвлөгөөний нээлт хаалтыг зохион байгуулах хөтөлгөч, хурлын заалны түрээс, кофены завсарлагаар үйлчлэхэд “Бидэр омбо” ХХК-д 9.8 сая төгрөг,
- Кибер аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, үндэсний кибер аюулгүй байдлын тогтолцоо, түүний үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах ажилд “Гэрэлт хан түшиг” ХХК-д 13.7 сая төгрөгийн урьдчилгаа өгч, 5.9 сая төгрөгийн өр төлбөртэй тайлагнасан.

Энэ нь Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д “Хуулийн этгээдийн хувийн хэрэг дараах мэдээллийг агуулна”: 10.1.2-т “хуулийн этгээдийн төрөл, хэлбэр, үйл ажиллагааны чиглэл”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-т “санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах;”, 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ажил үйлчилгээг авахдаа улсын бүртгэлийн гэрчилгээнд бүртгэлтэй үйл ажиллагааны чиглэл таарахгүй аж ахуй нэгжээр гүйцэтгүүлж, санхүүжилт олгосон зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 3: Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв УТҮГ-ын үндсэн чиг үүрэгт хамаарах ажлыг бусдаар гүйцэтгүүлж, дараах үр ашиггүй зарцуулалт гаргасан байна. Үүнд:

- Кибер халдлага зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таниулах чиг үүрэг бүхий газартай боловч Сэтгэл зүйн үйлчилгээний үндэсний төв ТББ-тай Цахим орчин дахь хүүхэд хамгааллын санаачилгын хүрээнд багш сурган хүмүүжүүлэгчид, сэтгэл зүйч, нийгмийн ажилтнуудад зориулсан 5 удаагийн сургалтыг зохион байгуулахад 17.6 сая

төгрөгийн шууд гэрээ байгуулж, 8.8 сая төгрөгийг шилжүүлж, гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй, үлдэгдэл төлбөрийг өр төлбөрөөр бүртгэж, тайлагнаагүй;

- Кибер халдлага зөрчилтэй тэмцэх чиглэлээр хийгдэж буй үйл ажиллагааг олон нийтэд танилцуулахаар Альфа гурвалжин ХХК, Хангарьд ХХК-тай нийт 40.0 сая төгрөгийн гэрээ байгуулж, 32.0 сая төгрөгийг шилжүүлсэн. Гэрээнд тусгагдсан контент бэлтгэх ажлыг гүйцэтгэсэн боловч олон нийтэд түгээх ажлын гүйцэтгэл хангалтгүй байхад гэрээ дүгнэсэн актаар хүлээн авч үлдэгдэл санхүүжилтийг олгохгүй байхаар шийдвэрлэсэн нь цаашид олон нийтэд түгээх зардал нэмэгдэх, хийгдсэн ажил нь үр нөлөөгүй болох эрсдэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах," Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2-т "Нийтийн төв дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:", 22.2.2-т "кибер халдлага, зөрчлийн талаар судалгаа, дүн шинжилгээ хийх, олон нийтэд зөвлөмж, мэдээлэл түгээх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах," Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 319 дүгээр тогтоолоор батлагдсан "Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв улсын төсөвт үйлдвэрийн газрын дүрэм"-ийн 2.2-т "Нийтийн төв нь Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 22.2-т заасан чиг үүргийг хэрэгжүүлэх бөгөөд чиг үүргийнхээ хүрээнд дараах чиглэлийн үйл ажиллагаа явуулна:", 2.2.5-д кибер аюулгүй байдлын чиглэлээр сургалт зохион байгуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үндсэн чиг үүрэгт хамаарах ажлыг бусдаар гүйцэтгүүлж, үр ашиггүй зарцуулалт гаргасан зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 4: Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв УТҮГ-ын захирлын А/46, А/60 дугаар тушаалаар нийт ажилтнуудын үндсэн цалингийн хэмжээг тогтоохдоо тооцоо судалгаанд үндэслэлгүйгээр хавтгайруулан 20 хувиар нэмэгдүүлж, нийт 44.8 сая төгрөгийн цалинг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх," 6 дугаар зүйлийн 6.2.5-д "төсвийн жилийн дундуур орлого бууруулах, зарлага нэмэгдүүлэх үр дагавартай бодлогын аливаа шийдвэр гаргасан бол түүнийг дараагийн төсвийн жилээс хэрэгжүүлдэг байх," 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах," 41 дүгээр зүйлийн 41.2.3-т "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах," 45 дугаар зүйлийн 45.2-т "Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ:", 45.2.1-д "нэгжид ногдох норм, нормативаар тооцон төсвийг нь баталсан ба гүйцэтгэл нь анх тооцсон нэгжийн тоо хэмжээнээс бага бол," 45.2.2-т "төлөвлөсөн төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйн улмаас, эсхүл тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдэгдэл," Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "үр ашигтай байх," 4.1.6-д "сахилга баттай байх," 4.1.9-д "хариуцлагатай байх," 15 дугаар зүйлийн 15.2.6-д "байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тооцоо судалгаанд үндэслэлгүйгээр нийт ажилтнуудын үндсэн цалинг хавтгайруулан 20 хувиар нэмж тогтоосон зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 5: Кибер аюулгүй байдлын зөвлөлийн ажлын алба 2025 оны төсвийн төсөлд тусгаж, батлуулаагүй зардлыг хичээл үйлдвэрлэлийн зардлаас танхимын түрээсийн зардалд 8.7 сая төгрөг, мэдээлэл технологийн зардлаас кибер халдлага, зөрчлийн мэдээлэл солилцооны дүн шинжилгээний санал хийлгэхэд 19.9 сая төгрөг, нийт 28.6 сая төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;”, 22 дугаар зүйлийн 22.6.3-т “төсвийн төлөвлөлт, бүртгэл, тайлагналтыг төсвийн ангиллын төрөл тус бүрээр, тэдгээрийн дэлгэрэнгүй ангиллын дагуу бэлтгэх;”, 41 дүгээр зүйлийн 41.2.3-т “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах;”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “үр ашигтай байх;”, 4.1.6-д “сахилга баттай байх;”, 4.1.9-д “хариуцлагатай байх;”, 2025 оны төсвийн тухай хууль, 2025 оны төсвийн төслийн саналтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн төслийн саналд тусгаж, батлагдаагүй ажил, үйлчилгээг санхүүжүүлсэн зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 6: Кибер аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албаны үндсэн чиг үүрэгт хамааралгүй ажлыг хэрэгжүүлэхээр 432.9 сая төгрөгийн "Иргэн, хуулийн этгээдэд чиглэсэн кибер халдлага, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах үндэсний тогтолцоог бэхжүүлэх үйлчилгээ" гэсэн нэртэй худалдан авах ажиллагааг зохион байгуулж, 432.9 сая төгрөгийн гэрээг Цахим аюулгүй байдлын мэдээлэл удирдлагын төв ГҮТББ-тай байгуулж, 50 хувийн санхүүжилтийг олгож, жилийн эцэст 216.4 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй тайлагнаж, үр ашиггүй зардал гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;”, 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;”, 41 дүгээр зүйлийн 41.2.3-т “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах;”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “үр ашигтай байх;”, 4.1.6-д “сахилга баттай байх;”, 4.1.9-д “хариуцлагатай байх;” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ажлын албаны чиг үүрэгт хамааралгүй ажлыг бусдаар гүйцэтгүүлэхээр төлөвлөж, санхүүжилт олгосон зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 7: Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй, тайлант оны төсвийн төсөлд тусгаж, батлуулаагүй дараах зардлуудыг санхүүжүүлсэн байна. Үүнд:

- Төрийн бус байгууллагаас "Сэтгэл хөдлөлөө удирдаж, өөрийгөө тайвшруулах нь" сэдэвт 5 цагийн сургалтад 13.4 сая төгрөг;
- Төрийн албан хаагчдын ажлын ачаалал, бүтээмжид үзүүлж байгаа цахимжилтын нөлөөллийг үнэлж, төрийн байгууллагуудын зохион байгуулалт хүний нөөцийн менежментэд хөндлөнгийн хяналт хийлгэх "Төрийн үйлчилгээний цахимжилт төрийн албан хаагчдын ачаалалд үзүүлсэн нөлөөллийн судалгаа"-ны ажил үйлчилгээний төлбөрт 19.0 сая төгрөг;
- Төрийн үйлчилгээний цахим шилжилтийг үр дүнтэй төлөвлөх, оролцогч талуудын бэлэн байдлыг сайжруулах зорилгоор "Төрийн үйлчилгээний цахим шилжилт ба оролцогч талуудын бэлэн байдлын үнэлгээний ажлын даалгавар боловсруулах" ажил үйлчилгээний төлбөрт 19.0 сая төгрөг;
- ChatGPT, Grok, Power BI программуудын лицензийн зардалд 34,146,248.00 /Гучин дөрвөн сая нэг зуун дөчин зургаан мянга хоёр зуун дөчин найман/ төгрөг.

Энэ нь Төсвийн тухай хуулийн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;”, 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;”, 41 дүгээр зүйлийн 41.2.3-т “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах;”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д “үр ашигтай байх;”, 4.1.6-д “сахилга баттай байх;”, 4.1.9-д “хариуцлагатай байх;” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгсөн төсвийн төслийн саналд тусгаж, батлагдаагүй ажил, үйлчилгээг санхүүжүүлэхгүй байх зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 8: Албан тушаалын тодорхойлолтод заагдсан үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллаж байгаа захиралд Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын чиглэл хүргүүлэх 01/1423 тоот албан бичгээр, ерөнхий нягтлан бодогч, тооцооны нягтлан бодогч, няравт И-Монгол академи УТҮГ-ын захирлын А/64 дүгээр тушаалаар 2 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний урамшуулалд нийт 28.8 сая төгрөг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ: 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;”, 23 дугаар зүйлийн 23.2-т “Нягтлан бодох бүртгэлийн ажилд үр бүтээл гарган ажилласан нягтлан бодох бүртгэлийн ажилтныг шагнаж урамшуулж болно.” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан тушаалын тодорхойлолтод заагдсан үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэн ажилласан захирал, санхүүгийн албан хаагчдад балансын урамшуулал олгосон зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

5.2.3 Зөвлөмж

Хөрөнгийн бүртгэлтэй холбоотой

Илрүүлэлт 1: Бараа материалын дансанд 9.3 сая төгрөгийн 16 ширхэг үндсэн хөрөнгө бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" УСНББОУС 17-Үндсэн хөрөнгө: "1 жилээс дээш хугацаагаар ашиглагдах, эдийн засгийн үр өгөөж эсвэл үйлчилгээний чадавхыг авчрах, өртгийг найдвартай үнэлэх боломжтой биет хөрөнгө гэж тодорхойлдог." гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: УСНББОУС, НБББББ-т тусгагдсаны дагуу үндсэн хөрөнгийг дансны ангилалын дагуу оновчтой бүртгэж байх.

Биет бус хөрөнгийн бүртгэлтэй холбоотой

Илрүүлэлт 2: И-Монгол академи УТҮГ-ын өөрийн хөгжүүлсэн, бусад байгууллагуудаас хүлээн авч ашиглалт, үйлчилгээг хариуцаж байгаа нийт 47 программ хангамж, системийг биет бус хөрөнгөд үнэлэн бүртгэж, тайлагнаагүй байна. Үүнд:

- Системийг эрх бүхий байгууллагын шийдвэрээр хүлээж авч, хөгжүүлэлт, үйлчилгээг хариуцаж байгаа 10 программ;
- Өөрсдөө хөгжүүлж ашиглалт, үйлчилгээг хариуцаж байгаа 37 программ хангамж

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ:", 14.4.2-т "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага;", УСНББОУС 31 Биет бус хөрөнгө " Хүлээн зөвшөөрөх шалгуур: ирээдүйд үр өгөөж бий болгох, өртгийг хэмжих боломжтой байх." гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Өөрийн хөгжүүлсэн болон бусад байгууллагуудаас хүлээн авч ашиглалт, үйлчилгээг хариуцаж буй программ хангамж, системүүдийг санхүүгийн тайланд бүртгэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2026 оны 12 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ													
1	ТЦҮЗГ	5	1,493.6	2	908.3	3	585.3	5	1,493.6	-	-	-	-
2	ЦХИХХЯ	2	48.2	-	-	2	48.2	2	48.2	-	-	-	-
	Дүн	7	1,541.8	2	908.3	5	633.5	7	1,541.8	-	-	-	-
ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР													
1	МЦХ ХК	5	2,871.9	2	243.0	3	2,628.9	5	2,871.9	-	-	-	-
2	МШ ХК	2	83.0	1	79.9	1	3.1	2	83.0	-	-	-	-
3	МТҮП ТӨААТҮГ	3	75.8	2	55.8	1	20.0	3	75.8	-	-	-	-
4	МХС ТӨХХК	2	21.1	-	-	2	21.1	-	-	2	21.1	2	21.1
5	ҮДТ УТҮГ	1	320.5	-	-	1	320.5	1	320.5	-	-	-	-
	Дүн	13	3,372.3	5	378.7	8	2,993.6	11	3,351.2	2	21.1	2	21.1
	Нийт дүн	20	4,914.1	7	1,287.0	13	3,627.1	18	4,893.0	2	21.1	2	21.1

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль хяналтын байгууллагад шилжүүлэх	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ													
1	ЦХИХХС	1	-	-	-	1	-	-	-	-	-	-	-
	Дүн	1	-	-	-	1	-	-	-	-	-	-	-
ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ													
1	ТЦҮЗГ	5	283.3	1	3.7	3	231.6	1	48.0	-	-	-	-
2	ЦХИХХЯ	13	1,036.5	2	53.3	8	844.7	2	20.0	1	118.5	1	248.7
3	И-Монгол академи УТҮГ	3	114.3	-	-	2	114.3	1	-	-	-	-	-
4	КАБЗАА	2	461.5	-	-	2	461.5	-	-	-	-	-	-
5	КХЗТНТ УТҮГ	6	134.1	1	1.3	4	123.5	1	9.3	-	-	-	-
	Дүн	29	2,029.7	4	58.3	19	1,775.6	5	77.3	1	118.5	1	248.7
ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САН													
1	БНҮҮС	4	555.2	-	-	3	251.0	1	304.2	-	-	1	65.9
	Дүн	4	555.2	-	-	3	251.0	1	304.2	-	-	1	65.9
ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР													
1	МЦХ ХК	7	327.1	2	9.7	3	172.1	2	145.3	-	-	-	-
2	МХС ТӨХХК	5	405.4	2	2.0	3	403.4	-	-	-	-	-	-
3	МШ ХК	6	789.1	2	3.3	3	749.0	-	-	1	36.8	-	-
4	МТҮП ТӨААТҮГ	8	977.3	1	2.6	5	137.5	2	837.2	-	-	-	-
5	ҮДТ УТҮГ	4	151.8	2	1.3	1	133.4	1	17.1	-	-	-	-
6	РТҮС УТҮГ	6	287.2	1	3.6	4	271.7	1	11.9	-	-	-	-
	Дүн	36	2,937.9	10	22.5	19	1,867.1	6	1,011.5	1	36.8	-	-
	Нийт дүн	70	5,522.8	14	80.8	42	3,893.7	12	1,393.0	2	155.3	2	314.6

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Д/д	Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс							
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТТЭЙ ХОЛБООТОЙ ЗӨРЧИЛ											
ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР											
1	МТҮП ТӨААТҮГ	1	198.1	-	-	-	-	1	198.1	-	-
	Дүн	1	198.1	-	-	-	-	1	198.1	-	-
БУСАД ХУУЛЬ ТОГТООМЖТОЙ ХОЛБООТОЙ ЗӨРЧИЛ											
ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ											
1	ЦХИХХС	1	-	-	-	1	-	-	-	-	-
	Дүн	1	-	-	-	1	-	-	-	-	-
ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ											
1	ЦХИХХЯ	8	-	-	-	2	-	6	-	-	-
2	ТЦҮЗГ	3	549.9	-	-	2	549.9	1	-	-	-
3	КАБЗАА	1	-	-	-	1	-	-	-	-	-
4	ЦХИХХС-ХО	2	14.8	-	-	-	-	2	14.8	-	-
	Дүн	14	564.7	-	-	5	549.9	9	14.8	-	-
ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САН											
1	БНҮҮС	1	-	-	-	-	-	1	-	-	-
	Дүн	1	-	-	-	-	-	1	-	-	-
ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР											
1	МЦХ ХК	3	-	-	-	1	-	2	-	-	-
2	МХС ТӨХХК	3	-	-	-	1	-	2	-	-	-
3	МШ ХК	3	-	-	-	-	-	2	-	1	-
4	ҮДТ УТҮГ	1	-	-	-	-	-	1	-	-	-
	Дүн	10	-	-	-	2	-	7	-	1	-
	Нийт дүн	27	762.8	-	-	8	549.9	18	212.9	1	-



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 1363/АОМН 371

Улаанбаатар хот

САГ - 2026/28/КА - СТА - ТЕЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2024 оны А/53 дугаар тушаалаар Кибер аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албаны үндсэн цалингийн хэмжээг 2,500,000.00 /Хоёр сая таван зуун мянга/ төгрөгөөс 5,500,000.00 /Таван сая таван зуун мянга/ төгрөгийн хооронд тогтоосон нь эрх зүйн үндэслэлгүй байна.

Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2024 оны "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 238 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт-д "Монгол Улсын Их Хуралд ажлаа хариуцан тайлагнадаг зарим байгууллагын ажлын алба болон адилтгах бусад байгууллага, зөвлөлийн ажлын албаны албан тушаалын цалингийн хэмжээ" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал." гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Ажлын албаны үндсэн цалингийн хэмжээг тогтоох эрхгүй албан тушаалтан ажлын албаны цалин тогтоосон зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гарахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд /Ч.Номин/-д даалгав.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:



С.МАГНАЙСҮРЭН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 1364/А0111371

Улаанбаатар хот

САГ-2026/28/МА-СТА-ТЭЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар 5,543,881,300.00 /Таван тэрбум таван зуун дөчин гурван сая найман зуун наян нэгэн мянга гурван зуу/ төгрөгийн 71 зөрчил илэрснээс 80,753,000.00 /Наян сая долоон зуун тавин гурван мянга/ төгрөгийн зөрчилд 14 төлбөрийн акт тогтоож, 3,893,706,800.00 /Гурван тэрбум найман зуун ерэн гурван сая долоон зуун зургаан мянга найман зуу/ төгрөгийн зөрчилд 41 албан шаардлага хүргүүлж, 1,414,086,000.00 /Нэг тэрбум дөрвөн зуун арван дөрвөн сая наян зургаан мянга/ төгрөгийн зөрчилд 14 зөвлөмж, 155,336,000.00 /Нэг зуун тавин таван сая гурван зуун гучин зургаан мянга/ төгрөгийн зөрчилд хариуцлага тооцуулах 2 албан шаардлага өгсөн байна. Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлөөс 1,278,300,000.00 /Нэг тэрбум хоёр зуун далан найман сая гурван зуун мянга/ төгрөгөөр өссөн байна.


Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т "Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:", 14.2.10-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх.", 69 дүгээр зүйлийн 69.3-т "Дотоод аудитад төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагааг хамаарна." гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал." гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдаагүй алдаа, зөрчлийг арилган, дотоод хяналтыг сайжруулж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гарахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд /Ч.Номин/, Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга /С.Цагаанхүү/ нарт даалгав.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:



(Signature)

С.МАГНАЙСҮРЭН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 1354/А0171238

Улаанбаатар хот

САГ - 2026/34/НА - СТА - ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд И-Монгол академи УТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй, тайлант оны төсвийн төсөлд тусгаж, батлуулаагүй дараах зардлуудыг санхүүжүүлсэн байна. Үүнд:

- Төрийн бус байгууллагаас "Сэтгэл хөдлөлөө удирдаж, өөрийгөө тайвшруулах нь" сэдэвт 5 цагийн сургалтад 13,400,000.00 /Арван гурван сая дөрвөн зуун мянган/ төгрөг;
- Төрийн албан хаагчдын ажлын ачаалал, бүтээмжид үзүүлж байгаа цахимжилтын нөлөөллийг үнэлж, төрийн байгууллагуудын зохион байгуулалт хүний нөөцийн менежементэд хөндлөнгийн хяналт хийлгэх "Төрийн үйлчилгээний цахимжилт төрийн албан хаагчдын ачаалалд үзүүлсэн нөлөөллийн судалгаа"-ны ажил үйлчилгээний төлбөрт 19,000,000.00 /Арван есөн сая/ төгрөг;
- Төрийн үйлчилгээний цахим шилжилтийг үр дүнтэй төлөвлөх, оролцогч талуудын бэлэн байдлыг сайжруулах зорилгоор "Төрийн үйлчилгээний цахим шилжилт ба оролцогч талуудын бэлэн байдлын үнэлгээний ажлын даалгавар боловсруулах" ажил үйлчилгээний төлбөрт 19,000,000.00 /Арван есөн сая/ төгрөг;
- ChatGPT, Grok, Power BI программуудын лицензийн зардалд 34,146,248.00 /Гучин дөрвөн сая нэг зуун дөчин зургаан мянга хоёр зуун дөчин найман/ төгрөг.

Энэ нь Төсвийн тухай хуулийн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;", 41 дүгээр зүйлийн 41.2.3-т "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах;", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "үр ашигтай байх;", 4.1.6-д "сахилга баттай байх;", 4.1.9-д "хариуцлагатай байх;" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал." гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230


Z: Alban Shoardlaga-20260424 SAG-22 Docx

1526182168

1. Өмнөх аудитаар өгсөн төсвийн төслийн саналд тусгаж, батлагдаагүй ажил, үйлчилгээг санхүүжүүлэхгүй байх зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гарахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг И-Монгол академи УТҮГ-ын захирал /М.Баттулга/, Ерөнхий нягтлан бодогч /Н.Солонго/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ТУСГАЙ ЧИГ ҮҮРГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР
АУДИТОР



Д.БАЯРСАЙХАН
П.ЧАНЦАЛДУЛАМ
Т.БААСАНЦЭНД
Г.ТЭЛМҮҮН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 1355/А0171238

Улаанбаатар хот

САГ-2026/34/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд И-Монгол академи УТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Албан тушаалын тодорхойлолтод заагдсан үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллаж байгаа захиралд Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын чиглэл хүргүүлэх 01/1423 тоот албан бичгээр, ерөнхий нягтлан бодогч, тооцооны нягтлан бодогч, няравт И-Монгол академи УТҮГ-ын захирлын А/64 дүгээр тушаалаар 2 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний урамшуулалд нийт 28,800,000.00 /Хорин найман сая найман зуун мянган/ төгрөг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ:”, 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;”, 23 дугаар зүйлийн 23.2-т “Нягтлан бодох бүртгэлийн ажилд үр бүтээл гарган ажилласан нягтлан бодох бүртгэлийн ажилтныг шагнаж урамшуулж болно.” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал.” гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Албан тушаалын тодорхойлолтод заагдсан үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэн ажилласан захирал, санхүүгийн албан хаагчдад балансын урамшуулал олгосон зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гарахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг И-Монгол академи УТҮГ-ын захирал /М.Баттулга/, Ерөнхий нягтлан бодогч /Н.Солонго/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ТУСГАЙ ЧИГ ҮҮРГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР
АУДИТОР

T. Mntee



Д.БАЯРСАЙХАН
П.ЧАНЦАЛДУЛАМ
Т.БААСАНЦЭНД
Г.ТЭЛМҮҮН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 1356/АД171238

Улаанбаатар хот

САГ-2026/99/НА-СТА-ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Кибер аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албаны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ажлын албаны үндсэн чиг үүрэгт хамааралгүй ажлыг хэрэгжүүлэхээр 432,900,000.00 /Дөрвөн зуун гучин хоёр сая есөн зуун мянган/ төгрөгийн "Иргэн, хуулийн этгээдэд чиглэсэн кибер халдлага, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах үндэсний тогтолцоог бэхжүүлэх үйлчилгээ" гэсэн нэртэй худалдан авах ажиллагааг зохион байгуулж, 432,897,117.10 /Дөрвөн зуун гучин хоёр сая найман зуун ерэн долоон мянга нэг зуун арван долоон төгрөг арван мөнгө/ төгрөгийн гэрээг Цахим аюулгүй байдлын мэдээлэл удирдлагын төв ГҮТББ-тай байгуулж, 50 хувийн санхүүжилтийг олгож, жилийн эцэст 216,448,558.10 /Хоёр зуун арван зургаан сая дөрвөн зуун дөчин найман мянга таван зуун тавин найман төгрөг арван мөнгө/ төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй тайлагнаж, үр ашиггүй зардал гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;" 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх;" 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" 41 дүгээр зүйлийн 41.2.3-т "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах;" Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "үр ашигтай байх;" 4.1.6-д "сахилга баттай байх;" 4.1.9-д "хариуцлагатай байх;" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал." гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Ажлын албаны чиг үүрэгт хамааралгүй ажлыг бусдаар гүйцэтгүүлэхээр төлөвлөж, санхүүжилт олгосон зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гарахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Кибер аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албаны дарга /Ч.Золбаяр/, санхүү, хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн /Г.Батчимэг/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ТУСГАЙ ЧИГ ҮҮРГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР
АУДИТОР

Т.Мөө



Д.БАЯРСАЙХАН
П.ЧАНЦАЛДУЛАМ
Т.БААСАНЦЭНД
Г.ТЭЛМҮҮН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойрог-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z: Alban Shaardlaga 20260424 SAG-22 Docs

1526182172



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 1357/А0171238

Улаанбаатар хот

САГ-2026/99/НА-СТА-ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Кибер аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албаны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны төсвийн төсөлд тусгаж, батлуулаагүй зардлыг хичээл үйлдвэрлэлийн зардлаас танхимын түрээсийн зардалд 8,674,900.00 /Найман сая зургаан зуун далан дөрвөн мянга есөн зуун/ төгрөг, мэдээлэл технологийн зардлаас кибер халдлага, зөрчлийн мэдээлэл солилцооны дүн шинжилгээний санал хийлгэхэд 19,926,000.00 /Арван есөн сая есөн зуун хорин зургаан мянган/ төгрөг, нийт 28,600,900.00 /Хорин найман сая зургаан зуун мянга есөн зуун/ төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх"; 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"; 22 дугаар зүйлийн 22.6.3-т "төсвийн төлөвлөлт, бүртгэл, тайлагналтыг төсвийн ангиллын төрөл тус бүрээр, тэдгээрийн дэлгэрэнгүй ангиллын дагуу бэлтгэх"; 41 дүгээр зүйлийн 41.2.3-т "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах"; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "үр ашигтай байх"; 4.1.6-д "сахилга баттай байх"; 4.1.9-д "хариуцлагатай байх"; 2025 оны төсвийн тухай хууль, 2025 оны төсвийн төслийн саналтай тус тус нийцэхгүй байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгч", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал." гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн төслийн саналд тусгаж, батлагдаагүй ажил, үйлчилгээг санхүүжүүлсэн зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гарахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Кибер аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албаны дарга /Ч.Золбаяр/, санхүү, хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн /Г.Батчимэг/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ТУСГАЙ ЧИГ ҮҮРГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР
АУДИТОР

T. Unteev



Д.БАЯРСАЙХАН
П.ЧАНЦАЛДУЛАМ
Т.БААСАНЦЭНД
Г.ТЭЛМҮҮН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 1358/А0171238

Улаанбаатар хот

САГ-2026/99/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Кибер аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албаны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2024 оны А/53 дугаар тушаалаар үндсэн цалингийн хэмжээг 2,500,000.00 /Хоёр сая таван зуун мянган/ төгрөгөөс 5,500,000.00 /Таван сая таван зуун мянган/ төгрөгийн хооронд тогтоосон нь Монгол Улсын Засгийн газрын 2024 оны "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 238 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтад зааснаас 2,784,000.00 /Хоёр сая долоон зуун наян дөрвөн мянган/ төгрөг хүртэл илүү байна.

Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2024 оны "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 238 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтад "Монгол Улсын Их Хуралд ажлаа хариуцан тайлагнадаг зарим байгууллагын ажлын алба болон адилтгах бусад байгууллага, зөвлөлийн ажлын албаны албан тушаалын цалингийн хэмжээ" гэж заасантай нийцэхгүй байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал." гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоолоор ажлын албаны албан хаагчдын албан тушаалын цалингийн хэмжээг тогтоох биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гарахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Кибер аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албаны дарга /Ч.Золбаяр/, санхүү, хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн /Г.Батчимэг/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ТУСГАЙ ЧИГ ҮҮРГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР
АУДИТОР

Т. Умраг



Д.БАЯРСАЙХАН
П.ЧАНЦАЛДУЛАМ
Т.БААСАНЦЭНД
Г.ТЭЛМҮҮН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 1359/A0171238

Улаанбаатар хот

САГ-2026/100/НА-СТА-ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв УТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Албан тушаалын тодорхойлолтод заагдсан үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэн ажилласан ерөнхий нягтлан бодогчид 1 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний 2,841,570.00 /Хоёр сая найман зуун дөчин нэгэн мянга таван зуун далан/ төгрөг, няравт 985,625.00 /Есөн зуун наян таван мянга зургаан зуун хорин таван/ төгрөгийн урамшууллыг тус улсын төсөвт үйлдвэрийн газрын захирлын А/36 тоот тушаалаар олгосон байна.


Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ:" 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" 23 дугаар зүйлийн 23.2-т "Нягтлан бодох бүртгэлийн ажилд үр бүтээл гарган ажилласан нягтлан бодох бүртгэлийн ажилтныг шагнаж урамшуулж болно." гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал." гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Албан тушаалын тодорхойлолтод заагдсан үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэн ажилласан санхүүгийн албан хаагчдад балансын урамшуулал олгосон зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гарахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв УТҮГ-ын захирал /Э.Амарсанаа/, Ерөнхий нягтлан бодогч /Г.Шүрэнцэцэг/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ТУСГАЙ ЧИГ ҮҮРГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР
АУДИТОР



Д.БАЯРСАЙХАН
П.ЧАНЦАЛДУЛАМ
Т.БААСАНЦЭНД
Г.ТЭЛМҮҮН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3. Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z: Alban Shoordlaga-2026M124 SAG-22 Docx

1526182178



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 1360/АО171238

Улаанбаатар хот

САГ-2026/100/НА-СТА-ТЦЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв УТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Анхан шатны баримтаар дэмжигдэхгүй, улсын бүртгэлийн гэрчилгээнд бүртгэлтэй үйл ажиллагааны чиг таарахгүй аж ахуйн нэгж рүү 34,085,000.00 /Гучин дөрвөн сая наян таван мянган/ төгрөгийг шилжүүлсэн нь бодит бус ажил гүйлгээ хийх эрсдэлтэй, байгууллагын дотоод хяналт сул байна. Үүнд:

- Албан хаагчдад "Төрийн албан хаагчийн ёс зүйн сургалт" авахад Дэл овоот ХХК-д 4,785,000.00 /Дөрвөн сая долоон зуун наян таван мянган/ төгрөг;
- CII summit 2025 уулзалт, зөвлөгөөний нээлт хаалтыг зохион байгуулах хөтөлгөч, хурлын заалны түрээс, кофены завсарлагаар үйлчлэхэд Бидэр омбо ХХК-д 9,800,000.00 /Есөн сая найман зуун мянган/ төгрөг,
- Кибер аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, үндэсний кибер аюулгүй байдлын тогтолцоо, түүний үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах ажилд Гэрэлт хан түшиг ХХК-д 13,650,000.00 /Арван гурван сая зургаан зуун тавин мянган/ төгрөгийн урьдчилгаа өгч, 5,850,000.00 /Таван сая найман зуун тавин мянган/ төгрөгийн өр төлбөртэй тайлагнасан.

Энэ нь Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д "Хуулийн этгээдийн хувийн хэрэг дараах мэдээллийг агуулна": 10.1.2-т "хуулийн этгээдийн төрөл, хэлбэр, үйл ажиллагааны чиглэл", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-т "санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах"; 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"; 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүрэг биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230


Z:\Alban_Shaardlaga_2026\0424_SAG-22.Docx

1526180180

зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал.” гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Ажил үйлчилгээг авахдаа улсын бүртгэлийн гэрчилгээнд бүртгэлтэй үйл ажиллагааны чиглэл таарахгүй аж ахуй нэгжээр гүйцэтгүүлж, санхүүжилт олгосон зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гарахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв УТҮГ-ын захирал /Э.Амарсанаа/, Ерөнхий нягтлан бодогч /Г.Шүрэнцэцэг/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН
ТУСГАЙ ЧИГ ҮҮРГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР
АУДИТОР



Д.БАЯРСАЙХАН
П.ЧАНЦАЛДУЛАМ
Т.БААСАНЦЭНД
Г.ТЭЛМҮҮН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 1361/А017/238

Улаанбаатар хот

САГ-2026/100/НА-СТА-ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв УТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв УТҮГ-ын захирлын А/46, А/60 дугаар тушаалуудаар нийт ажилтнуудын үндсэн цалингийн хэмжээг тогтоохдоо тооцоо судалгаанд үндэслэлгүйгээр хавтгайруулан 20 хувиар нэмэгдүүлж, нийт 44,800,000.00 /Дөчин дөрвөн сая найман зуун/ төгрөгийн цалинг олгосон байна.


Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохиотой удирдлагыг хэрэгжүүлэх," 6 дугаар зүйлийн 6.2.5-д "төсвийн жилийн дундуур орлого бууруулах, зарлага нэмэгдүүлэх үр дагавартай бодлогын аливаа шийдвэр гаргасан бол түүнийг дараагийн төсвийн жилээс хэрэгжүүлдэг байх," 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах," 41 дүгээр зүйлийн 41.2.3-т "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах," 45 дугаар зүйлийн 45.2-т "Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ," 45.2.1-д "нэгжид ногдох норм, нормативаар тооцон төсвийг нь баталсан ба гүйцэтгэл нь анх тооцсон нэгжийн тоо хэмжээнээс бага бол," 45.2.2-т "төлөвлөсөн төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйн улмаас, эсхүл тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдэгдэл," Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "үр ашигтай байх," 4.1.6-д "сахилга баттай байх," 4.1.9-д "хариуцлагатай байх," 15 дугаар зүйлийн 15.2.6-д "байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал." гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

- Тооцоо судалгаанд үндэслэлгүйгээр нийт ажилтнуудын үндсэн цалинг хавтгайруулан 20 хувиар нэмж тогтоосон зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
- Цаашид зөрчлийг давтан гарахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв УТҮГ-ын захирал /Э.Амарсанаа/, Ерөнхий нягтлан бодогч /Г.Шүрэнцэцэг/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ТУСГАЙ ЧИГ ҮҮРГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР
АУДИТОР



Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр.
Утас 51-261230

Z: Alban Shuardlaga 20260424 SAGI-22.Docx



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 1362/АД171238

Улаанбаатар хот

САГ-2026/100/НА-СТА-ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв УТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Улсын төсөвт үйлдвэрийн газрын үндсэн чиг үүрэгт хамаарах ажлыг бусдаар гүйцэтгүүлж, дараах үр ашиггүй зарцуулалт гаргасан байна. Үүнд:

- Кибер халдлага зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таниулах чиг үүрэг бүхий газартай боловч Сэтгэл зүйн үйлчилгээний үндэсний төв ТББ-тай Цахим орчин дахь хүүхэд хамгааллын санаачилгын хүрээнд багш сурган хүмүүжүүлэгчид, сэтгэл зүйч, нийгмийн ажилтнуудад зориулсан 5 удаагийн сургалтыг зохион байгуулахад 17,600,000.00 /Арван долоон сая зургаан зуун мянган/ төгрөгийн шууд гэрээ байгуулж, 8,800,000.00 /Найман сая найман зуун мянган/ төгрөгийг шилжүүлж, гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй, үлдэгдэл төлбөрийг өр төлбөрөөр бүртгэж, тайлагнаагүй;
- Кибер халдлага зөрчилтэй тэмцэх чиглэлээр хийгдэж буй үйл ажиллагааг олон нийтэд танилцуулахаар Альфа гурвалжин ХХК, Хангарьд ХХК-тай нийт 40,000,000.00 /Дөчин сая/ төгрөгийн гэрээ байгуулж, 32,000,000.00 /Гучин хоёр сая/ төгрөгийг шилжүүлсэн. Гэрээнд тусгагдсан контент бэлтгэх ажлыг гүйцэтгэсэн боловч олон нийтэд түгээх ажлын гүйцэтгэл хангалтгүй байхад гэрээ дүгнэсэн актаар хүлээн авч үлдэгдэл санхүүжилтийг олгохгүй байхаар шийдвэрлэсэн нь цаашид олон нийтэд түгээх зардал нэмэгдэх, хийгдсэн ажил нь үр нөлөөгүй болох эрсдэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2-т "Нийтийн төв дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:", 22.2.2-т "кибер халдлага, зөрчлийн талаар судалгаа, дүн шинжилгээ хийх, олон нийтэд зөвлөмж, мэдээлэл түгээх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;", Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 319 дүгээр тогтоолоор батлагдсан "Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв улсын төсөвт үйлдвэрийн газрын дүрэм"-ийн 2.2-т "Нийтийн төв нь Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 22.2-т заасан чиг үүргийг хэрэгжүүлэх бөгөөд чиг үүргийнхээ хүрээнд дараах чиглэлийн үйл ажиллагаа явуулна:", 2.2.5-д "кибер аюулгүй байдлын чиглэлээр сургалт зохион байгуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал.” гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Үндсэн чиг үүрэгт хамаарах ажлыг бусдаар гүйцэтгүүлж, үр ашиггүй зарцуулалт гаргасан зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гарахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв УТҮГ-ын захирал /Э.Амарсанаа/, Ерөнхий нягтлан бодогч /Г.Шүрэнцэцэг/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
ТУСГАЙ ЧИГ ҮҮРГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРЛАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *Д.Баярсайхан* Д.БАЯРСАЙХАН
АУДИТЫН МЕНЕЖЕР *Т.Мидеэ* П.ЧАНЦАЛДУЛАМ
АУДИТОР Т.БААСАНЦЭНД
АУДИТОР Г.ТЭЛМҮҮН





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 237/АО171238

Улаанбаатар хот

САГ-2026/100/НА-СТА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв УТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

"Тапатрип эжинси"ХХК-д 2024 онд шилжүүлж, урьдчилгаа дансанд бүртгэсэн боловч 2025 оны санхүүгийн байдлын тайланд үлдэгдлээр тайлагнасан 1,290,950.00 /Нэг сая хоёр зуун ерэн мянга есөн зуун тавин/ төгрөгийн онгоцны тийзний төлбөрийг улсын төсөвт төвлөрүүлээгүй байна.


Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.2.5-д "төсвийн жилийн дундуур орлого бууруулах, зарлага нэмэгдүүлэх үр дагавартай бодлогын аливаа шийдвэр гаргасан бол түүнийг дараагийн төсвийн жилээс хэрэгжүүлдэг байх", 41 дүгээр зүйлийн 41.2.3-т "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", 43 дугаар зүйлийн 43.1-д "Тухайн төсвийн жилд ашиглагдаагүй төсвийн дараах үлдэгдлийг төсвийн дараагийн жилд үргэлжлүүлэн зарцуулж болно:", 43.1.1-д "Засгийн газрын өрийн бичиг, зээлийн үндсэн болон хүүгийн төлбөр", 43.1.3-д "Улсын Их Хурлаас соёрхон баталсан, Засгийн газар хоорондын гэрээгээр болон олон улсын байгууллагын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төсөв", 43.1.5-д "төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан тусламж, хандив.", 45 дугаар зүйлийн 45.2-т "Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ:" 45.2.1-д "нэгжид ногдох норм, нормативаар тооцон төсвийг нь баталсан ба гүйцэтгэл нь анх тооцсон нэгжийн тоо хэмжээнээс бага бол," 45.2.2-т "төлөвлөсөн төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйн улмаас, эсхүл тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдэгдэл," Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "үр ашигтай байх," 4.1.6-д "сахилга баттай байх," 4.1.9-д "хариуцлагатай байх;" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн;" гэж заасныг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Төсөвт төвлөрүүлээгүй 1,290,950.00 /Нэг сая хоёр зуун ерэн мянга есөн зуун тавин/ төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв УТҮГ-ын захирал /Э.Амарсанаа/, ерөнхий нягтлан бодогч /Г.Шүрэнцэцэг/ нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ТУСГАЙ ЧИГ ҮҮРГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР
АУДИТОР



Д.БАЯРСАЙХАН
П.ЧАНЦАЛДУЛАМ
Т.БААСАНЦЭНД
Г.ТЭЛМҮҮН